



2020 оны 03 дугаар сарын 11  
№10 /1112/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Санхүүжилтийн ерөнхий  
хэлэлцээр соёрхон батлах тухай**

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

**Төрийн захиргааны албан  
тушаалын зэрэг дэв олгох тухай**

**Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол**

**Үндэсний хөтөлбөр батлах тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |  |     |
|------|--|--|-----|
| 132. | Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай |  | 605 |
|------|--|--|-----|

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 133. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай       | Дугаар 12 | 606 |
| 134. | Албан тушаалаас чөлөөлж, томилох тухай                 | Дугаар 15 | 606 |
| 135. | Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай | Дугаар 16 | 606 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |                                |            |     |
|------|--------------------------------|------------|-----|
| 136. | Үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 318 | 609 |
| 137. | Журам шинчлэн батлах тухай     | Дугаар 325 | 626 |

### МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- |      |                                 |  |     |
|------|---------------------------------|--|-----|
| 138. | Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр |  | 637 |
|------|---------------------------------|--|-----|

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

### САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлэх “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар  
сарын 13-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Нэмэхийн Батааг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Бархасын Доржийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар  
сарын 14-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

### Албан тушаалаас чөлөөлж, томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Зандаахүүгийн Энхболдын өөрийнх нь хүсэлтийг үндэслэн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, Өлзийхүүгийн Шижирийг мөн өдрөөс Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар  
сарын 14-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

### Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн



захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
2020 оны 02 дугаар сарын 14-ний  
өдрийн 16 дугаар зарлигийн хавсралт

**ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ  
ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИД**

№	Овог, нэр	Эрхэлж буй ажил	Албан тушаалын зэрэглэл	Олгох зэрэг дэв
1	Лувсандоржийн Өлзийсайхан	Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга	ТӨ-V	Тэргүүн зэрэг
2	Бямбажавын Ганбат	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга	ТӨ-VI	Тэргүүн зэрэг
3	Бадамцоогийн Идэрчулуун	Төрийн албаны зөвлөлийн гишүүн	ТӨ-VI	Тэргүүн зэрэг
4	Дамдинсүрэнгийн Даваасүрэн	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга	T3-15	Тэргүүн зэрэг
5	Дашдаваагийн Ганболд	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргаа, хүний нөөцийн газрын дарга	AA-2	Дэд зэрэг
6	Цэрэндоржийн Нарантунгалаг	Улсын Их Хурлын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга	AA-2	Дэд зэрэг
7	Даньхүүгийн Баянбилэг	Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга	AA-1	Гутгаар зэрэг
8	Энхбаатарын Бат-Идэр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга	AA-2	Гутгаар зэрэг
9	Ядамсүрэнгийн Баттогтох	Улсын Их Хурлын Тамгын газрын Дотоод аудитын албаны дарга	AA-2	Гутгаар зэрэг
10	Бэрэнбаралын Эрдэнэбилэгт	Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга	AA-2	Гутгаар зэрэг



11	Жигжидсүрэнгийн Бямбасүрэн	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн дарга	AA-3	Гутгаар зэрэг
12	Санжаагийн Наранцогт	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	T3-15	Гутгаар зэрэг
13	Гомбосүрэнгийн Өнөрбаяр	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга	T3-15	Гутгаар зэрэг
14	Володягийн Оюумаа	Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүн	TӨ-VA	Дөтгөөр зэрэг
15	Сүрэнхоролын Бат-Эрдэнэ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга	AA-2	Дөтгөөр зэрэг
16	Лүндэнбазарын Түвшинжаргал	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Зохион байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд Шадар туслах	AA-2	Дөтгөөр зэрэг
17	Нэргүйн Мягмар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга	AA-2	Дөтгөөр зэрэг
18	Пүрэвийн Зоригтбаатар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга	AA-2	Дөтгөөр зэрэг
19	Содномдаржаагийн Батбаатар	Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга	AA-2	Дөтгөөр зэрэг
20	Янжинлхамын Баасанбат	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн орон тооны шинжээч	AA-2	Дөтгөөр зэрэг
21	Жаргалсайханы Тамир	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга	AA-3	Дөтгөөр зэрэг
22	Чойжилжавын Эрдэнэчимэг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Хуулийн хэлтсийн дарга	AA-3	Дөтгөөр зэрэг
23	Хишигжаргалын Хэрлэн	Ашигт малтмал, газрын тосны газрын дарга	T3-14	Дөтгөөр зэрэг
24	Ганбаатарын Билгүүн	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	T3-15	Дөтгөөр зэрэг
25	Барсүрэнгийн Баасандорж	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга	T3-14	Дөтгөөр зэрэг

----oOo----

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 08 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 318

Улаанбаатар  
хот

### Үндэсний хөтөлбөр батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.6 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэн хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Н.ЦЭРЭНБАТ**

Засгийн газрын 2019 оны  
318 дугаар тогтоолын хавсралт

### **ХӨРС ХАМГААЛАХ, ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын 2015 оны Засгийн газар хоорондын хуралдаан дээр дэлхийн үржил шимт хөрс хурдацтайгаар багасч, хүн төрөлхтний өсөн нэмэгдэж байгаа хүнсний хангамжид сөргөөр нөлөөлөх хэмжээнд хүрээд байгааг тэмдэглэж, тогтвортой хөгжлийн 17 үндсэн зорилтын тэргүүлэх нэг асуудал болгосон.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Дэлхийн хүнсний аюулгүй байдал ба хүнс тэжээлийн салбарын нөхцөл байдал-2018” илтгэлд 2017 оны байдлаар өлсгөлөнд нэрвэгдсэн хүний тоо дэлхийд 821 саяд хүрсний гол шалтгаан нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө, хөрсний доройтол, усны хомсдлоос шууд хамааралтайг дурджээ.

Эдгээр шалтгааны улмаас Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2016-2025 оныг “Хүнс тэжээлийн арван жил”, Олон улсын Хөрс Судлалын Холбоо (IUSS)-ноос 2015-2024 оныг “Дэлхийн хөрсний арван жил” болгон зарлаж хөрсийг хамгаалах, тордон сайжруулах, ашиглалтын хэмнэлттэй горимд шилжих, хөрсний судалгааг нарийвчлан хийх зэрэг олон арга хэмжээ авахыг дэлхийн улс орнуудад уриалсан.

Монгол Улсын нутаг дэвсгэр газар зүйн тогтцын хувьд далайн түвшнээс өндөрт өргөгдсөн, эх газрын эрс тэс ширүүн уур амьсгалтай, гадаргын хотгор гүдгэрийн ялгаа их, байгалийн олон бүс, бүслүүрт хуваагддагаас шалтгаалж экосистемийн үндсэн бүрэлдэхүүн болох хөрсөн бүрхэвчийн хувьд гарал үүсэл, хэв шинжийн тархалт нь харилцан адилгүй, хөнгөн механик бүрэлдэхүүнтэй, үржил шимт хөрсний нөөц багатай, ачаалал даах, байгалийн аясаар нөхөн сэргэх чадавх сул юм.

Сүүлийн жилүүдэд тариалангийн нийт талбайн хөрсний 61.4 хувь нь хүчтэй, 34.9 хувь нь дунд, 3.7 хувь нь сул элэгдэлд орж, үржил шимийн үзүүлэлт буурсан байна.

Монгол оронд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 14.6 сая га талбай байгаагаас 1.3 сая га талбай ашиглалтын, 13.3 сая га талбай хайгуулын зорилгоор ашиглаж байна.

Уул уурхайн ашигт малтмал эрэх, хайх, олборлох зориулалтаар ашиглаж байгаа газрын нөхөн сэргээлтийг гүйцэтгэх, үнэлэх, хүлээн авах ажлын стандарт нэг мөр болж чадаагүй, нөхөн сэргээлтийг технологийн дагуу гүйцэтгэх мэргэжлийн хүний нөөц, техник материалын хангамж сул, техникийн болон биологийн нөхөн сэргээлт 40-60 хувь орчим байгаа бөгөөд эвдрэлд орсон хөрсийг нөхөн сэргээх асуудал хурц тавигдаж байгаа болно.

Авто замын эвдрэл болон хүний буруутай үйл ажиллагааны улмаас Улаанбаатар хот, 21 аймгийн төв, 330 сумын төв, багийн төв гээд суурин газрын хөрс ихээхэн хэмжээгээр талхлагдаж, элэгдэл, эвдрэлд орж байгаа бөгөөд Улаанбаатар хотын хөрсний 4.1 хувь нь сул, 25.7 хувь нь дунд зэрэг, 70.1 хувь нь хүчтэй эвдэрч доройтсон байна. Мөн хот, суурин газрын хөрсөн дэх хүнд металлуудын агууламжийг бэлчээрийн эрүүл хөрстэй харьцуулахад: Хром (Cr) 76.3 хувь, Хар тугалга (Pb) 71.1 хувь, Цайр (Zn) 80.3 хувь, Зэс (Cu) 65.8 хувь, Кадми (Cd) 48.7 хувь, Никель (Ni) 52.6 хувь

тус тус их байна. Хөрсний нянгийн бохирдолт 88 хувь, органик бохирдол 52.6 хувь, шивтэрийн бохирдол 88.4 хувь, сульфатын бохирдол 72 хувь болсон байна.

Улсын хэмжээнд нийт 396 хог хаягдлын төвлөрсөн цэг байгаагаас Улаанбаатар хотод байдаг 6 цэгт 2017 онд 1.1 сая тн хог хаяжээ. Эдгээр нь нийт 125 мянган га талбай эзэлж байгаа бөгөөд жил тутам хог хаягдлын хэмжээ 500 мянган тн-оор нэмэгдэж байгаа зэрэг нь хөрс бохирдоход ихээр нөлөөлж байна.

Монгол Улсын хөрс судалгааны нэгдсэн арга зүй, стандарт, нормативын баримт бичгүүд хоцрогдсон, уур амьсгалын өөрчлөлт, зах зээлийн үеийн аж ахуй эрхлэлтийн нөхцөлд дасан зохицоогүй, хөрсний шинжилгээ, бохирдол, доройтлын хяналтын сүлжээгүйгээс зөвхөн тодорхой зориулалтаар цөөн хэдэн цэгт нэг удаа авсан дээжээр нийт нутаг дэвсгэрийн хөрсний чанарыг дүгнэж байгаа нь хөрсний эдийн засгийн үр ашгийг тооцох, хүний эрүүл мэндийг хамгаалах, экологийн нөхцөлийг сайжруулах шийдвэр гаргахад үндэслэл болж чадахгүй байна.

Хөрсний элэгдэл, үржил шимээ алдсанаас эдийн засагт мөн хохирол учирч байгаагийн жишээ бол 2017 оны байдлаар тариалангаас атаршаад байгаа 241 мянган га талбайн хөрсийг зөв ашиглаагүйгээс 110 тэрбум орчим төгрөгийн өртөгтэй 193 мянган тн үр тариа хураан авах боломжийг алджээ.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалт”-ын 54-т “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлэхээр заасныг үндэслэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр” (цаашид “хөтөлбөр” гэх)-ийг боловсрууллаа.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

### 2.1. Хөтөлбөрийн зорилго

Хөрсний доройтлыг бууруулах, хөрсийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, хөрс хамгаалах урт хугацааны тогтвортой менежментийг бий болгож хөрсний экологи-эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

### 2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:





2.2.1. эрүүл хөрсийг хамгаалах, бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг нөхөн сэргээх замаар орчны төлөв байдлыг сайжруулж хүн амын эрүүл мэндийг хамгаалах;

2.2.2. хөрсийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбар дундын уялдааг хангасан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх;

2.2.3. хөрсний доройтол төлөв байдлын арга зүй, стандартыг боловсронгуй болгож, сургалтын болон мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, мэргэжлийн хүний нөөц бэлтгэх;

2.2.4. хөрсний чанарын болон экологи-эдийн засгийн үнэлгээг боловсронгуй болгох;

2.2.5. хөрсийг зохистой ашиглах, хамгаалах, доройтлоос сэргийлэх талаарх сургалт сурталчилгааг эрчимжүүлж, олон талын оролцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

#### Гурав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Эрүүл хөрсийг хамгаалах, бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг нөхөн сэргээж, ашиглах замаар орчны төлөв байдлыг сайжруулж хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. хими, биологийн болон бусад хорт бодисоор бохирдсон, доройтсон, үржил шимээ алдсан, хөрс бүхий нийт газрын 50 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, түүний 20 хүртэл хувийг бүрэн нөхөн сэргээж, дахин эргэлтэд оруулах;

3.1.2. гэр хорооллын дахин төлөвлөлт барилгажуулах хөтөлбөрт багтаагүй Нийслэлийн төвийн бүсийн гэр хорооллын 30 мянган айл өрхийг инженерийн дэд бүтцэд холбох;

3.1.3. байгалийн нөлөөгөөр (салхи, усны) элэгдэж эвдэрсэн нуралтад өртөх эрсдэлтэй газарт бутлаг ургамал тариалах, бэлчээр хамгаалах фитомелиорац<sup>1</sup> хийх, хамгаалалтын ойн зурвас байгуулах замаар агро-ойн мелиорацийн<sup>2</sup> арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.1.4. хөдөө аж ахуйн газрын хөрсний агрохими, бохирдол, хомсдлын экологийн судалгаанд тулгуурлан зураглал гаргаж агро химийн

<sup>1</sup> ургамал сайжруулах

<sup>2</sup> ой сайжруулах



ажлын өгөгдлийн баазад үндэслэн эрдэс бордоо хэрэглэх, давсжилт, намагжилтаас сэргийлж хөрсний хүчиллэгийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан тариалангийн зориулалтаар газар ашиглаж, эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэн өгч биелэлтэд хяналт тавих;

3.1.5. тариалангийн талбайн ашиглалтын бүртгэлийг сайжруулж хөрс нь элэгдэж эвдэрч үржил шимээ алдсан нийт 30798.9 га талбайг тариалангийн талбайг эргэлтээс хасч, олон настаар нөхөн сэргээж, бэлчээрт шилжүүлэх ажлыг өргөтгөх;

3.1.6. тариалангийн талбайн эргэлтийн системд уриншийн болон хөрсийг туйлдуулдаг таримал ургамлын эзлэх хувийг эрс бууруулж, олон наст болон бусад таримал тарихад бүх талын дэмжлэг үзүүлэх;

3.1.7. байгалийн нөлөөгөөр (салхи, усны) элэгдэж, эвдэрч, талхлагдсан, элсний нүүлт, цөлжилтийн улмаас доройтсон бэлчээр, тариалангийн газрын тооллого, бүртгэлийг хийж олон наст ургамал тариалах, хашиж хамгаалах, ашиглалтаас чөлөөлөх замаар бэлчээрийн төлөв байдлын суурь судалгаатай харьцуулахад 15 хувийг буюу 100.000 га бэлчээрийг нөхөн сэргээж, газрыг эргэлтэд оруулах;

3.1.8. хот, суурин газрын хог хаягдлын цэгүүдийн эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хог хаягдлыг бууруулах орон нутгийн хөтөлбөрүүдийн зорилтыг сайжруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.1.9. ашигт малтмал олборлосон газрын хөрсийг нөхөн сэргээх ажлын чанарыг дээшлүүлж байгалийн бүс, ашигт малтмалын төрөл, олборлолтын технологийг харгалзан ялгавартайгаар гүйцэтгэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3.1.10. нийслэл, бусад томоохон хотуудад байрладаг бүх төрлийн зах, худалдааны төв түүний орчинд хамаарах хөрсний чанар, эрүүл ахуйн стандартыг шинэчлэн мөрдүүлж орчны хөрс, агаарын чанарт хяналт тавих суурин цэгийг байгуулж, үйл ажиллагааны зардлыг тухайн зах, худалдааны төвөөс санхүүжүүлэх журам батлах;

3.1.11. нийслэл дэх худалдааны зах, төвүүдийн үйл ажиллагаанд хяналт-шалгалт хийж нөлөөллийн болон эрсдэлийн үнэлгээг тодорхойлон зах, худалдааны төвүүдийн тохижилтыг сайжруулах, нүүлгэн шилжүүлэх байршлын оновчтой шийдлийг сонгох;

3.1.12. худалдааны зах, төв, гэр хороолол, хогийн цэг, цахилгаан станц, шатахуун түгээх станц орчмын хүнд, металл, өвчин үүсгэгч



нянгаар бохирдсон газрыг физик болон биологийн аргаар цэвэршүүлэх, шаардлагатай тохиолдолд бохирдсон хөрсийг хуулж устгах арга хэмжээ авах;

3.1.13. гэр хорооллын айл өрх, малын гаралтай түүхий эд авдаг цэгүүд, нян үүсэх бохирдолтой цэгүүдэд ариутгалыг тогтсон хугацаанд хийж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.14. хот, аймгийн төвөөс алслагдсан болон гэр хорооллын дахин төлөвлөлтөд орсон байршилд байгаа айлуудыг эко жорлон, соруулах зориулалт бүхий бохирын нэгдсэн хураагууртай болгох;

3.1.15. байгаль орчин, хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн өмнө тулгарч байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхдээ газар ашиглалт, хөрсний үржил шимийг тогтвортой хамгаалахад суурилсан техник технологийн шийдлийг сонгох;

3.1.16. хөрсний бордооны үйлдвэрүүдийг өргөтгөж, шинээр нэмж байгуулах замаар хөрсийг бордох ажилд хэрэглэх бордооны үйлдвэрлэлийн хэмжээг 2023 онд 90.000 тн-д хүргэх.

3.2. Хөрсийг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбар дундын уялдааг хангасан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулж нөхөн сэргээх, ашиглах бодлогын хэрэгжилтийг нэгдмэл удирдлагаар хангахад чиглэсэн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нэмж тусгах;

3.2.2. газар, хөрстэй холбогдсон салбар, байгууллага хоорондын чиг үүргийн давхардлыг арилгах, яам, агентлаг, орон нутгийн удирдлагын хариуцлагыг дээшлүүлэх, салбар дундын уялдааг хангаж төсвийн болон бусад хөрөнгө оруулалт, санхүүжилтийг үр дүнтэй болгох, газар, хөрсний мэдээллийн санг адил тэгш, хүртээмжтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.3. хөрсний үнэт чанарт тулгуурлан газрын зохистой төлөвлөлт, хуваарилалтыг хийх, бохирдож доройтсон газар, хөрсийг нөхөн сэргээх, хөрс ашиглалтын технологийн горимыг мөрдөж, хамгаалалт, ашиглалтад тавих орон нутгийн төрийн байгууллагын хяналт, үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн арга зүйн болон эрх зүйн орчныг сайжруулах;

3.2.4. Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Газрын шинэтгэлийн үндэсний хорооны эрх, үүргийг хөрс хамгаалах чиглэлээр өргөтгөн хөрсний зэрэглэл, үнэлгээг тогтоох, хөрс хамгаалах ажлыг

урамшуулах дүгнэлтийг орон нутгийн төрийн байгууллагад хүргүүлэх салбар дундын эрдэмтэд, мэргэжилтний бүрэлдэхүүнтэй орон тооны бус байнгын комисс байгуулж ажиллуулах;

3.2.5. үндэсний хэмжээний аж үйлдвэрийн бүс, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зориулалтаар газрыг олгохдоо хөрсний экологи-эдийн засгийн үнэлгээ, одоо болон ирээдүй үеийн хүнсний тогтвортой, тасралтгүй нөөцийг бүрдүүлэх ач холбогдлыг харгалзах талаар холбогдох хуульд тусгах;

3.2.6. үржил шимт чанараараа бонитет<sup>3</sup>-ийн дээд зэрэглэлд хамаарах хөрс бүхий газрыг улс, орон нутгийн нөөцөд авч агро үйлдвэрлэлээс бусад зориулалтаар ашиглахыг хориглох талаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3.2.7. энэ хөтөлбөрийн 3.2.6-д зааснаас бусад зэрэглэлд хамаарах хөрс бүхий газрыг уул уурхай, үйлдвэрлэл, аж ахуйн зориулалтаар ашиглах тохиолдолд хөрсийг заавал хуулж, хадгалан дахин ашиглах талаар холбогдох хууль тогтоомж, стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.2.8. газар, хөрсийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг урамшуулахад газрын төлбөрийн орлогын зохих хувийг зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.2.9. ойн зурвас байгуулах, шимт бордоо хэрэглэх, хөрсөнд ээлтэй технологи нэвтрүүлэх зэргээр тариалангийн газрын хөрсний элэгдлийг бууруулж, үржил шимийг дээшлүүлсэн, үржил шим нь доройтож, атаршсан газрыг нөхөн сэргээн эргэлтэд оруулсан тохиолдолд газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, тухайн талбайг давуу эрхээр эзэмшүүлэх, өмчлүүлэх зэргээр тариалан эрхлэгчдийг урамшуулах тогтолцоог бий болгох;

3.2.10. хөрсийг бордох, ойн зурвас байгуулах зэрэг хөрс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэх, тариалан эрхлэгчдэд техник төхөөрөмж, шимт бордоо, тарьц, суулгац, үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох.

3.3. Хөрсний доройтол төлөв байдлын арга зүй, стандартыг боловсронгуй болгож, сургалтын болон мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, мэргэжлийн хүний нөөц бэлтгэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

<sup>3</sup> Бонитет- Хөрсний эдийн засгийн үнэ цэнийг тодорхойлоход ашигладаг хөрсний нэгж хэсэг талбай бүрийн бодит төлөв байдал болон ирээдүйн үр өгөөжийг агуулсан оноогоор илэрхийлэгддэг тоон үзүүлэлт.



3.3.1. хөрсний судалгаа шинжилгээний нэгдсэн арга зүйд үндэслэн хөрсний ангилал, зэрэглэл үйлдвэрлэлд хэрэглэх аргачлалыг боловсруулж, батлуулах;

3.3.2. ашиглалтын хэлбэрт нийцүүлэн хөрсний хайгуул-судалгаа, зураглалын ажлыг гүйцэтгэх, хөрсний шинж чанар болон төлөв байдлыг тодорхойлох, хөрсний дээжид лабораторийн задлан шинжилгээ хийх, хөрсний бохирдлын төрөл, зэрэглэлийг тогтоох;

3.3.3. хөрсний агрохимийн судалгаа болон экологи-эдийн засгийн үнэлгээ, зураглалд суурилсан үндэсний хэмжээний хөрсний мониторингийн сүлжээ байгуулах;

3.3.4. хөрсний төлөв байдал, ашиглалт, хамгаалалт, бохирдол, доройтлоос сэргийлэх, сөрөг үр дагаврыг арилгах санхүүжилттэй холбоотой статистик мэдээ, газар зүйн мэдээллийн системд тулгуурласан зурган болон тоон мэдээллийг Байгаль орчны мэдээллийн сан, түүний дэд сан болох “Хөрсний мэдээллийн сан”, “Орчны доройтол, бохирдлын мэдээллийн сан”-тай холбох, түүнчлэн салбар дундын хөрсний нэгдсэн мэдээллийн санг үүсгэн, үйл ажиллагааг үр дүнтэй болгох;

3.3.5. дэлхийн хөрсний мэдээллийг шинэчлэх ажлын хүрээнд азийн орнуудын хөрсний мэдээллийн тогтолцоонд нэгдэж, бүс нутгийн хэмжээнд тоон болон зураглалын сан үүсгэхэд оролцох;

3.3.6. хөрсний нөхөн сэргээлтийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлттэй холбоотой үндэсний стандартыг шинээр боловсруулж, олон улсын жишиг стандартыг нутагшуулах;

3.3.7. хөрсний стандартыг шинжилгээний, аж ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хамгаалал, нөхөн сэргээлтийн чиглэлээр ангилан системчлэх;

3.3.8. Монгол орны хөрсний үржил шимийн төлөв байдал, нөөцийг тогтоох, зураглал шинээр хийх;

3.3.9. хөрсний судалгаа, шинжилгээ хийдэг лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчнийг сургах, орчин үеийн шаардлага хангасан багаж, тоног, төхөөрөмж, урвалж бодисоор хангах, арга зүйг сайжруулах, олон улсын жишигт нийцэхүйц хөрс судлалын лабораторитой болох удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3.3.10. төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хөрсний судалгаа, шинжилгээний



лабораториудын чадавхыг орон нутгийн түвшинд дээшлүүлэх, хөрс хамгаалах техник технологийн шинэчлэл хийх;

3.3.11. нэгдсэн төлөвлөгөө гарган хөрс судлах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн мэргэжилтнүүдийг монголын болон бусад улсын их, дээд сургуулиудад бэлтгэх;

3.3.12. төрийн болон холбогдох төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудыг хөрс судлах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр тусгай хөтөлбөрийн дагуу сургалтад хамруулж, 2 жилд нэг удаа давтан сургах;

3.3.13. хөрс судлалын чиглэлийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг сайжруулах, сургалтын орчинг бүрдүүлэх шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

3.3.14. хөрсний бохирдол хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх талаар нөлөөллийн судалгааг хийж урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг арилгах арга хэмжээг тодорхойлж, хүний буруутай үйл ажиллагаанаас үүссэн хөрсний бохирдлын түвшинг тогтоох;

3.4. Хөрсний чанарын болон экологи-эдийн засгийн үнэлгээг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. хөрсний чанар, ангиллаас хамаарсан экологи-эдийн засгийн мөнгөн үнэлгээг тогтоож газар болон эд хөрөнгийн татвар, төлбөр, түрээсийн хэмжээг тогтоох, газрын дуудлага худалдаа зохион байгуулах, хөрсөнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээнд суурь болгон ашиглах;

3.4.2. газрын үнэлгээний тойрог, суурь үнэлгээ, газрын төлбөр, түрээсийн хэмжээ, арилжааны үнийг хөрсний экологи-эдийн засгийн үнэлгээг харгалзан тогтоож байх;

3.4.3. хөрсний чанарын үнэлгээг тогтоох нэгдсэн арга зүй боловсруулах;

3.4.4. хөрсний чанар, экологи-эдийн засгийн үнэлгээг боловсронгуй болгох чиглэлээр гадаад орнууд, олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэх;

3.4.5. хөрсний органик нүүрстөрөгчийн нөөцийн үнэлгээг хийж түүний алдагдлын байдал, нэмэгдүүлэх нөхцөлийг судалж доройтсон хөрсийг нөхөн сэргээх арга замыг илрүүлэх;



3.4.6. газар ашиглалтын төрөл, хөрсний элэгдэл эвдрэлээс шалтгаалсан хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад байгальд ээлтэй, дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололт, судалгаа шинжилгээний үр дүнд нэвтрүүлэх.

3.5. Хөрсийг зохистой ашиглах, хамгаалах, газрын доройтлоос сэргийлэх талаарх сургалт сурталчилгааг эрчимжүүлж, олон талын оролцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1. 2015-2024 оныг “Дэлхийн хөрсний 10 жил” болгон зарласантай холбогдуулан эрүүл хөрсний гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар иргэд, олон нийт, аж ахуй эрхлэгчдэд танин мэдүүлэх ажлыг төлөвлөгөөтэйгээр тогтмол сурталчлах;

3.5.2. нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл, ажилтнууд, үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчид, иргэдэд газар, хөрсийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр бүсчилсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3.5.3. хөрсний бохирдол, газрын доройтлыг үүсгэж байгаа хүчин зүйл, хор уршиг, тэдгээрээс сэргийлэх, хөрсний үнэ цэнийг ойлгуулах, хог хаягдлыг төвлөрсөн цэгүүдэд хаядаг болгох талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүргэх ажлыг тогтмолжуулах;

3.5.4. хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах чиглэлд идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулан дэмжих, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах;

3.5.5. аж ахуй эрхлэгчид хөрсийг зохистой ашиглах, хамгаалах туршлага, мэдээллээ харилцан солилцох, судлах, технологийн болон эдийн засгийн мэдлэгээ сайжруулахад чиглэсэн олон талт сургалтыг зохион байгуулж, чадавхжуулах, мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлэх;

3.5.6. хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах чиглэлээр ажилладаг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын оролцоо, үйл ажиллагааг дэмжиж төр, хувийн хэвшил, иргэдийн үр өгөөжтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх;

3.5.7. хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дэлхий, олон улс, бүс нутгийн байгууллага, мэргэжлийн холбоотой хамтын ажиллагааг хөгжүүлэх, бусад улс орны туршлагыг нутагшуулах, түгээн дэлгэрүүлэх.



## Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

4.1. Хөтөлбөрийг 5 жилийн хугацаанд дараах 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

4.1.1. I үе шат: 2019-2021 он;

4.1.2. II үе шат 2022-2023 он.

## Тав. Хөтөлбөрийн үр дүн

### 5.1. Хөтөлбөрийн үр дүн

5.1.1. эрүүл хөрсийг хамгаалах, бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг тордон сэргээснээр бохирдож доройтсон хөрсний 30 хувь, үүний дотор 100.000 га бэлчээрийг сэргээн эргэлтэд оруулна.

5.1.2. хот, суурин газрын хөрсийг бохирдуулагч эх үүсвэрийн 20 гаруй хувийг устгаж, 500 м<sup>3</sup> бохирдсон, доройтсон хөрсийг цэвэрлэн хөрсний бохирдлоос шалтгаантай өвчлөлтийг 20 хувь бууруулна.

5.1.3. хөрсийг хамгаалах эрх зүйн орчин сайжирч, салбар дундын уялдааг хангасан хөрсний удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдэнэ.

5.1.4. хөрсний судалгаа, шинжилгээний нэгдсэн арга зүйтэй болсноор хөрсний төлөв байдал, чанарын дүгнэлт үнэн зөв болж бохирдол, доройтлоос сэргийлэх, зохистой ашиглах арга технологийн сонголт тодорхой болно.

5.1.5. хөрс судлалын чиглэлээр сургалтын орчин, нөхцөлийг сайжруулснаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын мэргэжилтнүүдийн чадвар дээшилж хэрэгжүүлж байгаа арга хэмжээ бодитой болно.

5.1.6. хөрсийг байгалийн нөөцийн хувьд мөнгөн үнэлгээтэй болгож газрын арилжаа, төлбөр, тооцоо, хохирлын үнэлгээнд ашигласнаар хөрсний эдийн засгийн үр өгөөжийг бодитой дүгнэх, төсөвт оруулж байгаа хувь нэмрийг тооцох боломж бүрдэнэ.

5.1.7. уул уурхай, үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгч иргэд, хуулийн этгээд хөрсийг хамгаалах, нөхөн сэргээх, газрын доройтлыг бууруулах ач холбогдлыг танин мэдэж, гадаад улсын сайн туршлагаас суралцсанаар хөрс хамгаалагдаж, нөхөн сэргээх зардал буурна.





Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

№	Хөтөлбөрийн зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2018 он	Зорилтот түвшин	
				Он	Үзүүлэлт
Үр нөлөө					
Зорилго	Хөрсний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, бохирдол доройтлоос урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урт хугацааны тогтвортой менежментийг бий болгон нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх	Бохирдож, доройтсон хөрсний 30 хувь, үүний дотор 100.000 га бэлчээрийг сэргээн эргэлтэд оруулна.	100%	2023	30 % буурна.
		Хөрсний бохирдлоос шалтгаантай өвчлөлтийг 20 хувь бууруулна.	100%	2023	20% буурна.
		Хөрсийг хамгаалах, газрын доройтлыг бууруулах эрх зүйн орчин бүрдэж, салбар дундын уялдаа хангагдсан байна.	50%	2021	100% бүрдэнэ.
		Хөрсний бохирдол, доройтлоос сэргийлэх техник технологийн шинэчлэлийг 30 хувьд хийнэ.	100%	2021	30%
		Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын нийт 500 гаруй мэргэжилтнүүдийг хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах чиглэлээр сургалтад хамруулна.	100%	2023	80% хангагдана.
		Хөрсний төсөвт оруулж байгаа эдийн засгийн үр өгөөжийг 100 хувь тооцох боломж бүрдэнэ.	0%	2021	100% ашиглана.



		Бохирдож, доройтсон хөрсийг нөхөн сэргээхэд зарцуулах зардлын хэмжээ 5 хувь буурна.	0%	2023	5% буурна.
Үр дүн					
Зорилт 2.2.2	Эрүүл хөрсийг хамгаалах, бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг тордон сэргээж дахин ашиглах замаар орчны төлөв байдлыг сайжруулж хүн амын эрүүл мэндийг хамгаалах	Хими, биологийн болон бусад хорт бодисоор бохирдсон, доройтсон, үржил шимээ алдсан, хөрс бүхий газрын 50 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч тэдгээрийн 20 хүртэл хувийг бүрэн нөхөн сэргээж дахин эргэлтэд оруулсан байна.	0%	2020	30%
				2021	30%
				2022	30%
				2023	10%
		Барилгажуулах төлөвлөлтөд ороогүй нийслэлийн төв ба дунд бүсэд оршиж байгаа гэр хорооллын 30 мянган өрхийг дэд бүтцийн сүлжээнд холбосон байна.	1% Үлгэр жишээ гудамж	2020	20%
2021	20%				
2022	30%				
2023	30%				
		Худалдааны зах, гэр хороолол, хогийн цэг, цахилгаан станц, шатахуун түгээх станц орчмын хүнд металл, өвчин үүсгэгч нянгаар бохирдсон 350 га хөрсийг хуулж устгах арга хэмжээ авна.	Хийгдээ-гүй	2021	50 га
				2022	100 га
				2023	200 га



Зорилт 2.2.3.	Хөрсийг ашиглах, хамгаалахтай холбоотой хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх	Хөрс хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах бодлогын хэрэгжилтийг нэгдмэл удирдлагаар хангахад чиглэсэн эрх зүйн нэмэлт өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид оруулсан байна.	0	2020	Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах
				2021	Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах
		Хөрс хамгааллын асуудал хариуцсан чиг үүрэг бүхий боловсон хүчнээр аж үйлдвэр, уул уурхай, газар тариалан эрчимтэй хөгжиж байгаа орон нутгийн газар зохион байгуулалт, байгаль орчин, хөдөө аж ахуйн болон мэргэжлийн хяналтын төрийн байгууллагууд хангагдсан байна.	Одоо 2 орон тоо аймгуудын ХААГ-т	2020	42 орон тоо аймгуудын байгаль орчин, газрын харилцааны байгууллагад
			2021	50 орон тоо сумдад	
			2022	50 орон тоо сумдад	
		Хөрсний үнэт чанарт тулгуурлан газрын зохистой төлөвлөлт, хуваарилалтыг хийх, бохирдож доройтсон хөрсийг нөхөн сэргээх, хөрс ашиглалтын технологийн горимын мөрдөлт, ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавих арга зүй болон гарын авлагаар орон нутгийн төрийн байгууллага хангагдсан байна.	0%	2020	50 %
				2021	50%



Зорилт 2.2.4.	Хөрсний судалгаа, шинжилгээний арга зүй, стандартыг сайжруулж, сургалт болон мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх	Хөрсний судалгаа шинжилгээний нэгдсэн арга зүй, аргачлалыг боловсруулж хөрсний ангилал, зэрэглэлийг баталгаажуулж нийгмийн хэрэгцээ, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.	Байхгүй	2020	Боловсруулалтын ажлын 60%
				2021	100 %
		Хөрсний агрохимийн судалгаа болон экологи-эдийн засгийн үнэлгээ, зураглалд суурилсан үндэсний хэмжээний хөрсний мониторингийн сүлжээ байгуулсан байна.	Байхгүй	2019	Сүлжээ байгуулах ажлын 10%
				2020	40%
				2021	40%
				2022	10%
Хөрсний нөхөн сэргээлтийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлттэй холбоотой үндэсний одоо байгаа 48 стандартын 30-ыг шинэчилсэн байна.	0%	2020	15%		
		2021	45%		
		2022	40%		
Зорилт 2.2.5.	Хөрсний чанарын болон экологи-эдийн засгийн үнэлгээг боловсронгуй болгох	Хөрсний чанар, ангиллаас хамаарсан экологи-эдийн засгийн мөнгөн үнэлгээг тогтоосон байна.	0%	2019	10%
				2020	90%
		Хөрсний чанарын үнэлгээг тогтоох нэгдсэн арга зүй боловсруулсан байна.	0%	2019	30%
				2020	70%



Зорилт 2.2.6	Олон нийтэд хөрсийг зохистой ашиглах, хамгаалах сургалт сурталчилгааг эрчимжүүлж, олон талын оролцоо, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх	Нутгийн удирдлагын байгууллагын төлөөлөл, ажилтнууд, үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчид, иргэдэд хөрсийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр бүсчилсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж нийт 500 хүнд хөрсний талаар мэдлэг эзэмшүүлсэн байна.	0%	2020	30%
				2021	35%
				2022	25%
				2023	10%
		Хөрс хамгаалах чиглэлд идэвх санаачилгатай ажиллаж байгаа иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулан дэмжсэнээр иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлсэн байна.	0%	2019	10%
				2020	50%
	2021		100%		

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

7.1. Хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

7.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;

7.1.3. иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт;

7.1.4. бусад эх үүсвэр.

### Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

8.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангана.

8.2. Төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь салбарын, нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргах үүрэг хүлээнэ.

8.3. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах чиглэлийн төрийн бус байгууллага, их, дээд сургууль, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийг хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцуулж, чадавхыг бэхжүүлэх сургалтуудад хамруулна.

### Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Газрын харилцаа, хөдөө аж ахуй болон геологи, уул уурхай, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналт, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр гарган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр хяналт-шинжилгээ хийж, 2 жил тутам үнэлэн, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

9.3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ хөтөлбөрийн 8.2-т заасан тайланг хянан үзэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

9.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.5. Хөтөлбөрийн явцын болон үр дүнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл болно.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 08 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 325

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Хаягжуулалтын тухай хуулийн 4.7, 4.8, 4.9-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг бүрэн хаягжуулах, улсын хэмжээний хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

а/ улс, аймаг, нийслэлийн хэмжээний хаягийн мэдээллийн сан үүсгэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, олон улс, улсын чанартай авто замын дагуу шинээр үүссэн суурьшил болон тусгай хамгаалалттай газарт байгуулагдсан амралт, аялал жуулчлалын газар, тэдгээрийн барилга байгууламжийг тусгасан 1:1000-ны масштабтай байр зүйн зураг боловсруулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү);

б/ хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг газрын кадастрын болон хот байгуулалтын кадастрын мэдээллийн сантай холбох арга хэмжээ авч, хаягийн зурагт үндэслэсэн замчлал бүхий систем бий болгож хэрэглээнд нэвтрүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү);

в/ гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах үйл ажиллагаатай уялдуулан иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хаягийн мэдээллийг шинэчилж хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд нийцүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Б.Баасандорж);

г/ шуудангийн үйлчилгээ, хүргэлтийг хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд тулгуурлан боловсронгуй болгох чиглэлээр арга хэмжээ авахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Чинбат)-т;

д/ харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлах гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах болон хаягийн тэмдэг,

тэмдэглэгээний ашиглалт, хадгалалт, хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.

3. Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем бий болгох, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 280 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Х.БАДЕЛХАН**

Засгийн газрын 2019 оны  
325 дугаар тогтоолын хавсралт

**ГУДАМЖ, ЗАМ, ТАЛБАЙ, ҮЛ ХӨДЛӨХ ЭД  
ХӨРӨНГИЙГ ХАЯГЖУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлаж байгаа гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг Хаягжуулалтын тухай хуульд заасны дагуу хаягжуулахад энэ журмыг баримтална.

1.2. Энэ журмын зорилго нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгөд нэр, дугаар бүхий хаяг олгож, хаягийн мэдээллийн санд бүртгэх болон хаягжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.3. Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “хаяг” гэж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, батлагдсан газар зүйн нэр бүхий газар нутаг, хот, суурин газар дахь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн байршлыг тодорхойлсон үсэг, тооны илэрхийллийг;

1.3.2. “хаягжуулах” гэж гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулах, үл хөдлөх эд хөрөнгөд дугаар олгох, хаягийн мэдээллийн санд бүртгэх, хөтлөх, өөрчлөх, хүчингүй болгох,





хаягийн зураг зохиох, хаягийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байршуулах цогц үйл ажиллагааг;

1.3.3. “хаягийн зураг” гэж гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн нэр, дугаар, геокодоор бүртгэсэн байршлыг тусгасан байр зүйн зургийг;

1.3.4. “хаягийн иж бүрдэл” гэж гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн байршлын мэдээллийг шуудангийн нэгдсэн кодын хамт хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд дэлгэрэнгүй болон товчлол хэлбэрээр бүртгэсэн хаягийн нэгдсэн мэдээллийг;

1.3.5. “хаягийн жагсаалт” гэж гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягийн иж бүрдлээр нь бүртгэсэн хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн бүртгэлийг;

1.3.6. “хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем” гэж гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн бүртгэлийг удирдах, зохион байгуулах, хөгжүүлэх, өгөгдөл, мэдээлэл цуглуулах, солилцох, дамжуулах, боловсруулах, хадгалах боломжтой төрийн мэдээллийн бусад сантай харилцан уялдаа бүхий цогц үйл ажиллагаатай цахим програм хангамжийг.

1.4. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн давхардлыг арилгах, цэгцлэх зорилгоор хаягт өөрчлөлт оруулж болно.

Хоёр. Гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх,  
нэрэмжит болгох

2.1. Хот, суурин газрын гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох санал боловсруулах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллөөс бүрдсэн 9-11 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус комиссыг (цаашид “комисс” гэх) аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулна.

2.2. Комисс нь гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох саналыг боловсруулна.

2.3. Гэр хорооллын гудамжинд нэр өгөх, өөрчлөх саналыг сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх комисс боловсруулна.

2.4. Гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох саналыг иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага санаачилж болно.

2.5. Комисс гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох саналыг газар зүйн нэрийн болон хаягийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй тулган хянана.

2.6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох саналыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

2.7. Гудамж, талбайн нэрийг Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшилд гарамгай гавьяа байгуулсан түүхэн хүмүүсийн нэр алдрыг мөнхлөх, түүх, соёлын дурсгал, түүхэн уламжлалыг хадгалахад чиглэсэн болон олон нийтээс санал болгосон, утга агуулгын хувьд уялдаатай, энгийн, ойлгомжтой нэр үгээр нэрлэнэ.

2.8. Энэ журмын 2.6-д заасны дагуу гудамж, талбайд өгсөн нэрийг хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд тухай бүр бүртгэнэ.

#### Гурав. Хаягийн зураг зохиох, баталгаажуулах

3.1. Хаягийн зургийг Монгол Улсын нийт нутаг дэвсгэрээр болон засаг захиргаа, нутаг дэвсгэр тус бүрээр үйлдэх бөгөөд нийтийн хэрэгцээний хаягийн зураг, төлөвлөлтийн хаягийн зураг гэж ангилна.

3.2. Хаягийн зургийг хот, тосгон, бусад суурин газарт 1:1000-1:5000-ны масштабтай, бусад газарт 1:25000-1:100000-ны масштабтай үйлдэнэ.

3.3. Хаягийн зурагт гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг байршлын дагуу тусгана.

3.4. Хаягийн зургийг хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд үндэслэн боловсруулна.

3.5. Аймаг, нийслэлийн Засаг даргын Газрын харилцаа, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хаягийн зураг боловсруулах ажлыг зохион байгуулна.

3.6. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн өөрчлөлтийг газрын кадастрын болон хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэгдсэний дагуу хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд тоон хэлбэрээр бүртгэж, хаягийн зурагт өөрчлөлт оруулна.

3.7. Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангуулах зориулалттай тусгай объектын байрлал, нэр, дугаарыг хаягийн жагсаалт, хаягийн зурагт тусгахыг хориглоно.



### Дөрөв. Хаягийн иж бүрдэл, хаягжуулах

4.1. Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хүснэгт 1-д заасан хаягийн иж бүрдлийн загварын дагуу хаягжуулж, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэнэ.

#### Хүснэгт-1

Хаягийн иж бүрдэл	Нийслэлд	Аймагт
Улс:	Монгол Улс	Монгол Улс
Аймаг, нийслэл:	Улаанбаатар	Архангай
Сум, дүүрэг:	Чингэлтэй	Их тамир
Баг, хороо:	1 (хороо)	1 (баг)
Шуудангийн бүсчлэлийн код:	15201	65170
Гудамжны (газар зүйн) нэр:	Жуулчны	Бор толгой
Үл хөдлөх эд хөрөнгө: -хашаа; -барилга байгууламж; -объект:	1205 202 -	2208 509 Өв 2
Орц:	1	1

4.2. Хаягийн иж бүрдэлд хороолол, хотхоны нэр, өрөө, сууцны давхрын дугаар, геокод (тухайн газар, үл хөдлөх эд хөрөнгө, байршил, эсхүл объектын байршилд харгалзах уртраг, өргөрөг бүхий солбицол), бизнес хаяг зэрэг бусад мэдээллийг нэмэлтээр бүртгэж болно.

4.3. Хаягийн иж бүрдлийг хураангуй болон дэлгэрэнгүй хэлбэрээр сонгон хэрэглэж болно.

4.4. Шуудангийн хүргэлтэд хаягийн иж бүрдлийг “Нэгдсэн хаягжуулалт, Хаягийн бичвэрт тавих шаардлага” MNS 6275 стандартад заасны дагуу дэлгэрэнгүй болон хураангуйлсан хэлбэр, шуудангийн нэгдсэн код, холбогдох шуудангийн салбарын нэр, дугаар, шуудангийн хайрцгийн дугаар, шуудан хүргэлтийн шугамын дугаар зэрэг холбогдох мэдээллийн хамт бичиж хэрэглэнэ.

4.5. Дэлгэрэнгүй болон хураангуй хаягийг Монгол хэлний тухай хууль, Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, Кирилл монгол бичгийн дүрэм, “Монгол бичгийн цагаан толгой” MNS 4333:1996 стандарт



болон “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283 стандартыг баримтална.

4.6. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталгаажуулаагүй хаягийн зургийг хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд оруулахгүй.

Тав. Үл хөдлөх эд хөрөнгөд байршлын хаяг олгох

5.1. Үл хөдлөх эд хөрөнгөд кадастр, байр зүйн гүйцэтгэлийн зургийг үндэслэн байршлын хаяг олгоно.

5.2. Дараах үл хөдлөх эд хөрөнгөд байршлын хаяг олгоно:

5.2.1. өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар;

5.2.2. өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газрын дээрх болон доорх барилга байгууламж;

5.2.3. тусгай-зориулалтын барилга байгууламж.

5.3. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх бүхий газарт бий болсон төслийн шатанд байгаа буюу дуусаагүй барилга байгууламжид урьдчилсан хаяг олгож болно.

5.4. Газрын харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үл хөдлөх эд хөрөнгөд байршлын хаяг авах хүсэлтийн загварыг боловсруулан мөрдүүлнэ.

5.5. Аймгийн төвийн сум, нийслэл, дүүрэгт тухайн шатны Засаг даргын газрын харилцаа, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймгийн төвийн сумаас бусад суманд газрын даамал үл хөдлөх эд хөрөнгөд байршлын хаяг олгоно.

5.6. Хот, суурин газрын зуслангийн бүсэд байрлах амины орон сууц, байшин, бусад төрлийн барилга байгууламжид аймаг, нийслэлийн Засаг даргын газрын харилцаа, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 6.5-д заасныг баримтлан байршлын хаяг олгоно.

5.7. Тусгай зориулалтын барилга байгууламжийг холбогдох төрийн захиргааны байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын газрын харилцаа, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байр зүйн гүйцэтгэлийн зургийг үндэслэн байршлын хаяг олгоно.



5.8. Дараах үл хөдлөх эд хөрөнгөд байршлын хаяг олгохгүй:

5.8.1. Өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүсээгүй газар, түүн дээр баригдсан үл хөдлөх эд хөрөнгө;

5.8.2. Цэвэр, бохир ус, дулаан, хий, цахилгаан, эрчим хүч, харилцаа холбооны дамжуулах, түгээх шугам сүлжээ;

5.8.3. Түр барилга байгууламж.

Зургаа. Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах аргачлал

6.1. Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг энэ журам, холбогдох стандартын шаардлагын дагуу хаягжуулна.

6.2. Гудамж, талбайн ижил утга, агуулга бүхий нэрэнд шинж чанарыг тодорхойлсон тодотгол хэрэглэж болно.

6.3. Гудамж, талбайн нэрийг түүхэн хүний нэрээр нэрлэсэн тохиолдолд нэрийг нь товчлон бичихгүй, овгийг товчилж болох бөгөөд нэрэнд орсон үг бүрийг том үсгээр эхлүүлэн бичнэ. Нэрэнд мэргэжил, мэргэжлийн зэрэг, цолыг оруулж болно. Жишээлбэл: “Л.Дандарын гудамж”, “Хатанбаатар Магсаржавын гудамж”, “Сүхбаатарын талбай” гэх мэт.

6.4. Гудамж, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг дараалсан хувьсах дугаарлалтын аргаар дугаарлана. Жишээлбэл: “гудамж I бол 100-199”, “Гудамж II бол 200-299”, “гудамж XII бол 1200-1299” гэх мэт.

6.5. Гудамж, үл хөдлөх эд хөрөнгийн дугаарыг тухайн нутаг дэвсгэрийн суурьшлын төвөөс гадагш чиглүүлэх байдлаар эхлүүлэн дугаарлах бөгөөд дугаарлалтын эхлэлийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

6.6. Гудамжийг уулзвараас дараагийн уулзвар хооронд дугаарлана. Гудамжны нэрийн ард үл хөдлөх эд хөрөнгийн дугаарыг зураас татаж бичнэ. Жишээлбэл: Ц.Жигжиджавын гудамж-302 гэх мэт.

6.7. Өргөн чөлөө, гудамжны дагуу байрлаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийг гудамжны эхлэлээс дэс дараалан дугаарлах бөгөөд гудамжны баруун талд байрлаж байгааг тэгш тоогоор, зүүн талд байрлаж байгааг сондгой тоогоор дугаарлана.

6.8. Гудамж тойрог хэлбэртэй тохиолдолд баруун талаас нь эхлэл тогтоож, цагийн зүүний дагуу дараалсан хувьсах аргаар үл хөдлөх хөрөнгийг дугаарлана.

6.9. Үл хөдлөх эд хөрөнгийн дугаарыг үсэг, тоо нэмэх боломжтой байдлаар бичиж дугаарлана.

6.10. Цогцолбор барилга байгууламжийн хувьд нэгдсэн нэг дугаар олгох бөгөөд тухайн цогцолборт хамаарах барилга, байгууламж тус бүрийг нэгдсэн дугаарын ард ташуу зураас татаж тоо нэмэх замаар дугаарлана. Жишээлбэл: 102/1, 102/2 гэх мэт.

6.11. Үл хөдлөх эд хөрөнгө нэгдэхэд тухайн нийт үл хөдлөх эд хөрөнгийн хамгийн их дугаарыг тавина. Жишээлбэл: “202, 204 нэгдэхэд 204”, “102, 102a нэгдэхэд 102” гэх мэт.

6.12. Газрын нэгж талбар хуваагдах тохиолдолд дугаарын ард жижиг үсэг нэмэх замаар дугаарлана. Жишээлбэл: “1202 нь 1202a, 1202б болох” гэх мэт.

6.13. Зуслан, гэр хорооллын хашаанд байрлах гэр, амины сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг хашааны адил дугаарлах бөгөөд тухайн хашаанд хэд хэдэн үл хөдлөх хөрөнгө байгаа тохиолдолд хашааны дугаарын ард ташуу зураас татаж тоо нэмэх замаар дугаарлана. Жишээлбэл: “102, 102/1, 102/2” гэх мэт.

6.14. Үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийтийн орон сууцны зориулалттай барилга байгууламжийг дугаарлахдаа байрлаж байгаа гудамжтай нь шууд хамааруулан дугаарлана.

6.15. Нийтийн зориулалттай орон сууцны байран дахь сууцыг нэг давхраас эхлэн цагийн зүүний дагуу дугаарлана.

6.16. Тусгай барилга, байгууламжийг хүснэгт 2-т заасан загварын дагуу дугаарын өмнө тухайн барилга байгууламжийн нэрийг товчлон бичиж дугаарлаж болно. Жишээлбэл: “цахилгаан дамжуулах байгууламжийн хаягийг “ЦТП301”, Ерөнхий боловсролын 105 дугаар сургуулийг “С105” гэх мэт.

Хүснэгт-2

№	Барилга байгууламжийн нэр	Товчлол
1	Гүний худаг	“ГХ”
2	Цэвэр усны усан сан	“УС”
3	Цэврийн насос станц	“ЦНС”



4	Ус түгээх байр	“УТБ”
5	Дулааны цахилгаан станц	“ДЦС”
6	Цахилгааны дэд станц	“ДС”
7	Цахилгааны хуваарилах байгууламж	“РП”
8	Цахилгааны дэд өртөө	“ТП”
9	Дулааны коллектор станц	“ДКС”
10	Дулааны насос станц	“ДНС”
11	Ус, дулаан хуваарилах төв	“УДХТ”
12	Трансформатор	“ТР”
13	Харуулын байр	“ХБ”
14	Гараж	“Г”
15	Шатахуун түгээх станц	“ШТС”
16	Нэвтрүүлэх станц	“НС”
17	Төмөр замын объект	“ТЗ”
18	Мэдээлэл холбоо сүлжээний нэгдсэн төв	“МХС”
19	Шуудангийн салбар	“ШС”
20	Үүрэн холбооны бааз станц	“ҮХС”
21	Бохирын насос станц	“БНС”
22	Цэвэрлэх байгууламж	“БЦБ”
23	Сургууль	“С”
24	Цэцэрлэг	“Ц”
25	Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны цогцолбор барилга	“БЗД1”

6.17. Хот, суурин газраас бусад орон нутагт байрлах нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалтын дагуу бий болоогүй гудамж, зам, талбай, өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар, үл хөдлөх эд хөрөнгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, газар зүйн нэрийг үндэслэн зориулалтаар нь дугаарлаж, байршлын хаяг олгоно. Жишээлбэл: “Өвөрхангай аймаг, Сант сум, 2 дугаар баг, Цагаан толгой, Өвөлжөө 01” гэх мэт.

6.18. Хот, суурин газар дахь гэр хорооллын амины орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө буюу хашаа, байшингийн дугаар шуудангийн бүсчлэлийн код дотор давтан дугаарлагдаж болно.

6.19. Энэ журмын 6.18-д зааснаас бусад тохиолдолд шуудангийн бүсчлэлийн код дотор үл хөдлөх эд хөрөнгийн дугаар давтагдахгүй байна.

Долоо. Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг эрхлэх, нийтэд хүргэх

7.1. Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем нь хаягийн бүртгэлийн эх баримт бичиг, хаягийн мэдээллийн сан, хаягийн зураг болон тусгай цахим програм хангамжаас бүрдэнэ.

7.2. Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг улс, нийслэл, аймаг, дүүрэг, сумын хэмжээнд тогтмол хөтлөн явуулах бөгөөд хаягийн бүртгэл, мэдээлэл цуглуулах, өөрчлөх, баталгаажуулах болон хаягийн бүртгэл, мэдээллийг нийтэд хүргэх, холбогдох төрийн байгууллагатай мэдээлэл солилцох хэлбэрээр ашиглана.

7.3. Улсын хэмжээний хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг Хаягжуулалтын тухай хуулийн 4.6-д заасан газрын харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хөтөлж, нэгдсэн удирдлага, хяналт, зохион байгуулалтаар хангана.

7.4. Аймаг, нийслэлийн хэмжээний хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг аймаг, нийслэлийн газрын асуудал, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн хөтөлж, Улсын хэмжээний хаягийн мэдээллийн нэгдсэн сангийн системийг бүрдүүлнэ.

7.5. Сумын газрын даамал, дүүргийн газрын алба хамаарах нутаг дэвсгэрийн хэмжээний хаягийн бүртгэлийг хөтөлж, аймаг, нийслэлийн хэмжээний хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг бүрдүүлнэ.

7.6. Үл хөдлөх эд хөрөнгө устаж үгүй болох, эсхүл буулган шинээр баригдсан тохиолдолд эрх бүхий байгууллагын актыг үндэслэн хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем дэх байршлын хаягт өөрчлөлт оруулна.

7.7. Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамаарах нутаг дэвсгэрт авто замын тухай, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, журмын дагуу олон улс, улсын болон орон нутгийн авто замын дагуу байрлуулсан замын тэмдэг, тэмдэглэгээний байрлалыг хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэнэ.

7.8. Хаягжуулалтын мэдээллийг дараах хэлбэрээр нийтэд мэдээлнэ:

7.8.1. хаягийн зураг, цомог, жагсаалт зохиож, нийтэд түгээх;

7.8.2. хаягийн зураг, мэдээлэл бүхий мэдээллийн самбарт байршуулах;

7.8.3. хаягжуулалтын өөрчлөлтийн талаар олон нийтийн





мэдээллийн хэрэгслээр мэдээлэх.

7.9. Газрын харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийн холбогдох хууль тогтоомж, журмаар тогтоосон нууц мэдээллийг хадгалах, хамгаалах арга хэмжээ авна.

Найм. Хаягийн тэмдэглэгээг үйлдвэрлэх,  
байрлуулах

8.1. Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээ, түүнийг байрлуулах стандартыг газрын харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулан мөрдүүлнэ.

8.2. Тухайн шатны Засаг дарга гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээг байрлуулах ажлыг хариуцан зохион байгуулна.

8.3. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн байршлын хаягийн тэмдэглэгээг энэ журмын 8.1-д заасан стандартын дагуу байрлуулна.

8.4. Засаг захиргааны нэгжийн хил зааг, хаягийн мэдээллийг “Нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжийн хаягийг мэдээлэх самбар”-т тусгаж, олон улс, улсын чанартай авто замыг дайран өнгөрөх байрлалд Хаягжуулалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журам, стандартад нийцүүлэн байрлуулна.

8.5. Хаягийн тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

Ес. Хаягжуулах үйл ажиллагааны санхүүжилт

9.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хаягжуулах үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, шаардагдах санхүүжилтийг зохих журмын дагуу улс, орон нутгийн төсөвт тусгуулна.

9.2. Засаг захиргааны нэгжид өөрчлөлт орсон тохиолдолд хаягийн бүртгэл, хаягжуулахад шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

9.3. Энэ журмын 9.1, 9.2-т зааснаас бусад тохиолдолд хаягт

өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргасан тал хаягжуулах ажлын зардлыг хариуцна.

Арав. Бусад

10.1. Хаягжуулалтын тухай хууль, журам болон стандартын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын болон газрын харилцаа, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус хяналт тавина.

10.2. Энэ журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтан холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

## **МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

### **САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улс: **Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр**

#### **Талууд**

Монгол Улсын Засгийн газар (цаашид “Монгол Улс” гэх) болон Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх) нь энэхүү Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр (цаашид “СЕХ” гэх)-ийг 2019 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр байгуулав.

#### **Үе шатлалт санхүүжилтийн сангийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр**

Үе шатлалт санхүүжилтийн сан (цаашид “ҮШСС”, “Сан” гэх) Хуваарь 1-д тайлбарлав. 2019 оноос 2029 оныг хүртэл хэрэгжих хөтөлбөрийн Хөрөнгө оруулалтын нийт өртөг нь 163.51 сая ам.доллар байхаар тооцоолсон болно.

#### **Үе шатлалт санхүүжилтийн сан**

ҮШСС-гийн зорилго нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд энэхүү СЕХ-т тусгасан нөхцөл журмын дагуу Хуваарь 4-т заасан шалгуурыг хангасан гурван төслийг санхүүжүүлэхэд оршино.

Эдгээрт дараах бүтээгдэхүүнүүд хамаарна. Үүнд:

- (i) **Хот суурин газар болон хөдөө орон нутагт анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бэхжүүлэх.** Энэхүү бүтээгдэхүүний хүрээнд (а) анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ (АШЭМТҮ)-ний санхүүжилт, хүний нөөц, гэрээлэлт



болон үйлчилгээний зохион байгуулалтад шинэчлэл хийх; (б) Улаанбаатар хотын гэр хорооллын ядуурал ихтэй хэсэгт 10 жишиг өрхийн эрүүл мэндийн төв (ӨЭМТ) болон сонгосон аймгуудын зургаан суманд сумын эрүүл мэндийн төвийг нүүрс хүчлийн хийн ялгарал багатай технологи ашиглан шинээр байгуулах; (в) эрүүл мэндийн үйлчилгээний тасалдалгүй байдлыг хангах үүднээс анхан болон хоёрдогч шатны эрүүл мэндийн цогц/нэгдсэн тусламж үйлчилгээний загварыг хэрэгжүүлэх; (г) АШЭМТҮ-ний төлөвлөлт, төсөвлөлт, зохицуулалт болон хяналтын чиглэлээрх институцийн болон хүний нөөцийн хөгжлийг дэмжих; болон (д) Улаанбаатар хот болон аймгуудыг хамарсан телемедицин болон агаарын тээвэрт суурилсан яаралтай тусламжийн үндэсний системийг бий болгоно.

(ii) **Аймаг, дүүргийн эмнэлгийн үйлчилгээг сайжруулах.** Энэхүү бүтээгдэхүүний хүрээнд (а) Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт шинэ дүүргийн эмнэлэг байгуулах; (б) нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг технологи ашиглан Хан-Уул дүүргийн болон Ховд аймгийн эмнэлгийг өргөтгөн шинэчлэх, Увс аймгийн эмнэлгийг өргөтгөх; (в) эрх зүйн зохицуулалт, менежментийн систем, гэрээлэлтийн чадавх, болон чадавхыг бэхжүүлэх замаар эмнэлгийн бие даасан байдалд дэмжлэг үзүүлэх; болон (г) засвар үйлчилгээ болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн загваруудыг судална.

(iii) **Эрүүл мэндийн санхүүжилт сайжирна.** Энэхүү бүтээгдэхүүний хүрээнд (а) стратегийн худалдан авалтын загварыг бий болгох; (б) стратегийн худалдан авалттай<sup>1</sup> холбогдуулж чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг Сангийн яам болон Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-тай хэрэгжүүлэх; (в) нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих институцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх; болон (г) эрүүл мэндийн даатгалын байгууллага (ЭМДБ)-ын чадавхыг төлөвлөлт, гэрээлэлт, зардлын тооцоолол болон сангийн менежментийн чиглэлээр сайжруулна.

(iv) **Холбогдох эрүүл мэндийн төрийн байгууллагуудын худалдан авах ажиллагаа болон санхүүгийн менежментийг сайжруулах.** Энэхүү бүтээгдэхүүний хүрээнд (а) ЭМЯ-ны дотоод үйл явцыг үнэлж, худалдан авалт, санхүүгийн болон эрсдэлийн удирдлагын

<sup>1</sup> Стратегийн худалдан авалт гэж үйлчилгээ үзүүлэгчдээс эрүүл мэндийн үйлчилгээг идэвхтэй, нотолгоонд суурилсан байдлаар худалдан авахыг хэлэх ба ингэхдээ эрүүл мэндийн тэргүүлэх чиглэл, зардлын үр-ашигт байдал, үйлчилгээний зохистой хэм хэмжээ мөн үйлчилгээ үзүүлэгчийн хослол (төрийн, хувийн хувшил)-д тулгуурлан нийгмийн эрх ашгийг дээд түвшинд байлгахаар худалдан авахыг хэлнэ.

чиглэлээр институцийн болон чадавхыг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлэх, мөн (б) ЭМЯ-наас удирдан хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд дэх дотоод аудит, эрсдэлийн удирдлагын чиг үүрэгт дүн шинжилгээ хийж чадавхыг сайжруулна.

Энэхүү СЕХ нь АХБ-нд аливаа санхүүжилт олгох хууль зүйн үүрэг хүлээлгэх үндэслэл болохгүй. АХБ нь Монгол Улсын гаргасан санхүүжилтийн аливаа хүсэлтээс татгалзах, Сангийн ашиглагдаагүй хөрөнгийг буцаан татах, цуцлах болон Сангаас санхүүжилт хүсэх Монгол Улсын эрхийг цуцлах эрхтэй. АХБ нь Сангийн талаарх энэхүү СЕХ-т тусгасан ерөнхий нөхцөл хэрэгжиж байна гэж үзсэнээр үе шатлалт санхүүжилтийг олгож болно.

Энэхүү СЕХ нь Монгол Улсын хувьд санхүүжилт хүсэх хууль зүйн үүргийг хүлээлгэх үндэслэл болохгүй. Монгол Улс нь Сангийн хүрээнд санхүүжилт хүсэхгүй байх эрхтэй. Түүнчлэн, Монгол Улс нь Сангийн хүрээнд шийдвэрлэсэн аливаа хөрөнгийг хэдийд ч буцаах эрхтэй.

Монгол Улс болон АХБ нь Сангийн хүрээнд ашиглагдаагүй аливаа хөрөнгийг цуцлах тус тусын эрхээ хэрэгжүүлж болно. АХБ нь санхүүжилтийн хүсэлтэд татгалзах эрхээ нөгөө талд бичгээр мэдэгдэл өгөх замаар хэрэгжүүлж болно. Бичгээр өгсөн мэдэгдэлд хүсэлтийг цуцлах эсхүл татгалзах болсон үндэслэлээ тайлбарлах бөгөөд цуцлах, эсхүл хүсэлтэд татгалзах болсон бол хүчинтэй болох өдрийг тусгана. АХБ нь АХБ-ны бодлого эсхүл СЕХ-т заасан нөхцөл журмыг зөрчсөн, санхүүжилтийн хүсэлтийг хугацаандаа гаргаагүй, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт саатсан тохиолдолд Санг цуцлах эсхүл санхүүжилтийн хүсэлтэд татгалзаж болно.

### **Санхүүжилтийн төлөвлөгөө**

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжүүлтийн төлөвлөгөөний хураангуйг дор үзүүлэв.

Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн өртөг нь татвар, төлбөр, хураамж, магадалшгүй зардал, хүү болон хэрэгжилтийн хугацаанд төлөх хураамжийг оролцуулаад нийт 163.51 сая ам.доллар байна. ҮШСС-ийн хүрээнд гурван төслийг 10 жилийн хугацаанд дараах нөхцөлд хэрэгжүүлнэ. Үүнд: Засгийн газраас холбогдох үечилсэн санхүүжилтийн хүсэлтийг гаргасан, санхүүжилтийн үе шат бүрийн зээлийн болон төслийн хэлэлцээрийг байгуулсан, мөн СЕХ-т заасан нөхцөл, журмыг хангасан. ҮШСС-ийн хүрээнд АХБ-ны Энгийн эх үүсвэрээс (ЭЭҮ) энгийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр нийт 158.34 сая ам.долларын зээлийг олгох бөгөөд Харилцан кредит олгох механизмын Японы сангаас 3.48 сая ам.долларын санхүүжилт олгоно. Зээлийн хөрөнгийг Азийн хөгжлийн банкны 2017 онд батлагдсан



Зээлийн зарцуулалтын гарын авлага (тухай бүрийн нэмэлт, өөрчлөлтийн хамт) болон Зээлийн хэлэлцээрийн нөхцөл болзлуудын дагуу олгоно.

**Санхүүжүүлтийн төлөвлөгөөний хураангуй**  
(сая ам.доллар)

Эх үүсвэр	Үе шат (ҮСХ-ийг гаргах онууд)			Нийт	Эзлэх хувь (%)
	1 (2019)	2 (2022)	3 (2025)		
Азийн хөгжлийн банк					
ЭЭҮ (энгийн зээл)	66.14	40.71	41.49	148.34	90.72
ХЭЭҮ (хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл)	10.00	–	–	10.00	6.11
Харилцан кредит Олгох Механизмын Японы Сан <sup>а</sup>	3.48	–	–	3.48	2.13
Монгол Улсын Засгийн газар	0.82	0.42	0.45	1.69	1.03
<b>Нийт</b>	<b>80.44</b>	<b>41.13</b>	<b>41.94</b>	<b>163.51</b>	<b>100.00</b>

ЭЭҮ = Энгийн эх үүсвэр, ҮСХ = Үечилсэн санхүүжилтийн хүсэлт.

<sup>а</sup> Азийн хөгжлийн банк захиран зарцуулдаг.

<sup>б</sup> 1.69 сая ам.долларын татвар, хураамжийг оролцуулан тооцсон ба Засгийн газар түүнээс чөлөөлөх хэлбэрээр санхүүжүүлнэ. Энэхүү дүн нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зардлын томоохон хэсгийг эзлэхгүй болно.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банкны тооцоолол.

**Санхүүжилтийн нөхцөл**

Монгол Улс энэхүү хэлэлцээрийн нөхцлийг мөрдөж, төслүүд эдгээр нөхцлийг хангаж буй тохиолдолд АХБ Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүд санхүүжилт авахад бэлэн болмогц тухайн төслүүдийг санхүүжүүлэхээр зээл болон хамтарсан санхүүжилтийн буцалтгүй тусламжийг олгоно. Зээл эсхүл буцалтгүй тусламж тус бүр нэг үе шатыг бүрдүүлнэ.

Үе шат тус бүрийг түүний өмнөх эсхүл дараагийн үе шатны санхүүжилтийн нөхцлөөс ялгаатай нөхцлөөр санхүүжүүлж болно. Санхүүжилтийн нөхцлийг төслийн онцлог, тухайн үе шатны хэлэлцээрийг байгуулах үеийн хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, АХБ-ны санхүүжилтийн бодлогод тулгуурлан тогтооно.

Үе шатны санхүүжилтийг дараалан эсхүл нэгэн зэрэг олгож болох бөгөөд зарим үед давхцуулж болно.

Үе шатлалт санхүүжилтийн санд хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж, баталгааны төлбөр оногдуулахгүй. Хураамжийг зөвхөн АХБ-наас зээлийн хэлбэрээр олгосон бодит санхүүжилтэд оногдуулна. Санхүүжилт олгох тухайн үе шатны хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр хүчин төгөлдөр үйлчилж буй АХБ-ны хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж болон баталгааны төлбөрийн журам үйлчилнэ.

### **Санхүүжилтийн хэмжээ**

Сангаас олгох санхүүжилтийн дээд хэмжээ нь 161.82 сая ам.доллар байна. Үүнд: (i) энгийн эх үүсвэр (ЭЭҮ)-ээс 148.34 сая ам.доллар, (ii) хөнгөлөлттэй энгийн эх үүсвэр (ХЭЭҮ)-ээс 10 сая ам.доллар, болон (iii) Харилцан кредит олгох механизмын Японы сангаас олгох буцалтгүй тусламжийн 3.48 сая ам.долларын хамтарсан санхүүжилт багтана.

### **Хүчинтэй хугацаа**

Сангаас хийх төлбөрийн сүүлийн хугацаа 2029 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байна. Сүүлчийн үе шатлалт санхүүжилт нь 2025 оны 2-р улирлаас хэтрэхгүйгээр дууссан байна.

### **Нөхцөл**

Монгол Улс нь сангийн хөрөнгийг энэхүү СЕХ болон тухайн үе шатны зээлийн хэлэлцээрт заасан нөхцөл, журмын дагуу Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд гарах зардлыг санхүүжүүлэхэд ашиглана.

### **Гүйцэтгэл**

Гүйцэтгэгч байгууллага нь ЭМЯ байна. Гүйцэтгэгч байгууллага нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг энэхүү СЭХ-ийн Хуваарь 1-т заасан зарчим, үе шатлал тус бүрийн хэлэлцээр тус бүрт нэмж тусгаснаар хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч байгууллагууд нь ЭМЯ болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар байна.

### **Үечилсэн санхүүжилтийн хүсэлт**

Монгол Улс Сангийн нөөцөөс Хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор зээл, хамтарсан санхүүжилтийн буцалтгүй тусламжийг авах хүсэлтийг Үечилсэн санхүүжилтийн хүсэлт (ҮСХ)-ээр гаргаж АХБ үүнийг зөвшөөрч болно. ҮСХ-ийг Сангийн яам (СЯ)-аар баталгаажуулан Монгол Улсаас хүргүүлнэ. Монгол Улс холбогдох ҮСХ болон тухайн үе шатны хэлэлцээрийн дагуу тухайн үе шатны санхүүжилтийг ЭМЯ-д олгоно.

Үе шат тус бүрийн санхүүжилтийн хэмжээ дөчин сая ам.доллар (\$40,000,000) эсхүл түүнтэй адилтгах хэмжээнээс багагүй байна. АХБ нь ҮСХ-ийг хянаж шаардлагыг хангасан гэж үзвэл холбогдох хэлэлцээрийг бэлтгэнэ.



ҮСХ-ийн хүрээнд санхүүжилт авах төслүүд нь Хуваарь 4-т заасан сонгон шалгаруулалтын шалгуур хангагдсан, зохих магадлан хийгдсэн, холбогдох хамгааллын болон итгэлцлийн ерөнхий хүрээ, бусад баримт бичигт нийцсэн байх шаардлагатай. Санг энэхүү СЕХ-ийн Хуваарь 3-т заасан ерөнхий хүрээ, Монгол Улсын Засгийн газар болон АХБ харилцан тохиролцсон Санг захиран хэрэгжүүлэх гарын авлагын дагуу хэрэгжүүлнэ.

Монгол Улсаас өөрөөр мэдэгдээгүй бол СЯ-ыг ҮСХ-д гарын үсэг зурах эрхтэй Монгол Улсын итгэмжлэгдсэн төлөөлөгч гэж үзнэ.

### **Хэрэгжилтийн ерөнхий хүрээ**

Санг энэхүү хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан ерөнхий хүрээний дагуу хэрэгжүүлнэ.

### **Журам**

Сангийн нөөцөөс санхүүжилт хийгдэх үе шатууд нь дараах журам, нөхцлийг хангана. Үүнд:

- (i) Монгол Улс нь ҮСХ-ийг хүргүүлэхээс энэ талаар АХБ-нд урьдчилан мэдэгдэнэ.
- (ii) Монгол Улс нь АХБ-тай харилцан тохиролцсон загварын ҮСХ-ийг хүргүүлнэ.
- (iii) АХБ нь санхүүжилтийн аль нэг үе шаттай холбогдох аливаа хэлэлцээрийн талаар хэлэлцээ хийх буюу байгуулахаас өөрийн үзэмжээр татгалзах болно.
- (iv) Хэрэв АХБ нь ҮСХ-ийг зөвшөөрч буйгаа баталгаажуулбал талууд хэлэлцээ хийж, хэлэлцээр байгуулна.

### **ҮСХ-ийн мэдээлэл**

ҮСХ нь тохиролцсон загварын дагуу бэлтгэгдэж дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- (i) Зээл, буцалтгүй тусламж, баталгаа эсхүл хамтарсан санхүүжилтийн хэмжээ;
- (ii) Санхүүжүүлэх төслийн танилцуулга;
- (iii) Зардлын тооцоо ба санхүүжүүлэх төлөвлөгөө;
- (iv) Тухайн төслийг хэрэгжүүлэх тусгайлсан зохицуулалтууд;
- (v) Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр хэвээр бөгөөд түүнийг үргэлжлүүлэн мөрдөж буй талаарх баталгаа;
- (vi) Өмнөх Зээлийн хэлэлцээр болон Төслийн хэлэлцээрийн (хэрэв хамааралтай бол) заалтуудыг мөрдөж буй талаарх баталгаа; болон
- (vii) Санг захиран хэрэгжүүлэх гарын авлагын дагуу шаардагдах эсхүл АХБ-ны үндэслэлтэйгээр хүсч болох бусад мэдээлэл.

**Хамгаалал**<sup>2</sup> Сангийн хөрөнгийг захиран хэрэгжүүлэх явцад дагаж мөрдөх Хамгааллын хүрээг Хуваарь 5-д тусгасан болно.

Тухайн үе шатны санхүүжилтийг АХБ-наас батлах хэлэлцээрийг байгуулах өдөр хүчин төгөлдөр үйлчилж буй АХБ-ны Хамгааллын бодлогыг тухайн санхүүжилтийн үе шатны хүрээнд хэрэгжүүлж буй төслүүдэд мөрдөнө.

### **Худалдан авах ажиллагаа ба үйлчилгээ**

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх бүх ажил, бараа, үйлчилгээг АХБ-ны Худалдан авах ажиллагааны бодлого (2017 онд батлагдсан бөгөөд түүнд орох нэмэлт, өөрчлөлтийн хамт) болон АХБ-ны Зээлдэгчдэд мөрдүүлэх худалдан авах ажиллагааны журам (2017 онд батлагдсан бөгөөд түүнд орон нэмэлт, өөрчлөлтийн хамт)-ын дагуу худалдаж авна.

### **Урьдчилсан гэрээ, нөхөн санхүүжилт**<sup>3</sup>

АХБ нь зохих хүсэлтийг үндэслэн бодлого, журмын дагуу үе шат бүрийн хүрээнд (а) зөвлөхийг урьдчилан гэрээ байгуулах болон (б) зээл хүчин төгөлдөр болохоос өмнө, гэхдээ тухайн үе шатны хэлэлцээрт гарын үсэг зурахаас 12 сараас дээшгүй хугацааны өмнө гарсан тухайн санал болгосон зээлийн 20 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээнд зөвлөхийн зөвшөөрөгдсөн зардлыг нөхөн санхүүжүүлэх зөвшөөрлийг олгож болно. Ийнхүү урьдчилан гэрээ байгуулах зөвшөөрөл олгосноор АХБ холбогдох төслийг санхүүжүүлэх үүрэг хүлээхгүй болохыг Монгол Улс хүлээн зөвшөөрч буй болно.

### **Зарцуулалт**

Сангийн нөөцөөс санхүүжих аливаа үе шатны хаалтын өдөр нь 2029 оны 3 дугаар сарын 31-нд эсхүл түүнээс өмнө байна. Санхүүжилтийг АХБ-ны Зээлийн зарцуулалтын гарын авлага (2017 онд батлагдсан бөгөөд түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хамт)-ын нөхцлийн дагуу зарцуулна.

### **Хяналт шинжилгээ, үнэлгээ ба тайлагнах тогтолцоо**

Сангийн нөөцөөс хэрэгжих эхний төслийн зээлийн эсхүл буцалтгүй тусламжийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш гурван сарын дотор ЭМЯ нь АХБ-нд хүлээн зөвшөөрөгдөхүйц хөтөлбөрийн гүйцэтгэлийн менежментийн системийг бий болгоно. Энэхүү хөтөлбөрийн гүйцэтгэлийн менежментийн систем нь Сангийн хүрээнд хэрэгжих Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, буцалтгүй тусламжийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийж, үнэлэхэд дэмжлэг үзүүлнэ. ХГМС-т Хяналт шинжилгээний ерөнхий хүрээнд тусгагдсан бүтээгдэхүүн болон үр дүнгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тусгах ба үүнд тусламж үйлчилгээний гүйцэтгэл, хөрөнгө

<sup>2</sup> АХБ. 2009. Хамгааллын бодлогын баримт бичиг. Манила хот.

<sup>3</sup> Монгол Улсын Засгийн газрын зөвшөөрөлтэйгээр.





оруулалтын гүйцэтгэл болон байгууллагын тодорхой үе шат дахь үр дүнгийн үзүүлэлтүүд хамаарна. ЭМЯ-ны Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж нь эдгээр үзүүлэлт тус бүрийн суурь мэдээллийг боловсруулж жил бүр судалгаа хийж, судалгааны үр дүнг үзүүлэлт тус бүрээр АХБ-нд мэдээлнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж дүгнэх Хөтөлбөрийн Хяналт шинжилгээний ерөнхий хүрээг Хуваарь 2-т тусгасан болно.

### Үүрэг

Монгол Улсын хүлээх үүргийг Хуваарь 6-д тусгасан болно.

**Монгол Улс**

**Азийн хөгжлийн банк**

**ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР**

**ЁЛАНДА ФЕРНАНДЕЗ ЛОММЕН**

**Сайд**

**Монгол Улсыг хариуцсан захирал**

**Сангийн яам**

**Суурин төлөөлөгчийн газар**

## ХУВААРЬ 1

### Үе шатлалт санхүүжилтийн сангийн бүрдэл хэсгүүд

#### А. Ерөнхий зураглал

**1.Салбарын стратеги, замын зураглал.** Монгол Улсын Засгийн газар иргэддээ үр дүнтэй, чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх стратегийг Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тусгасан. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах замаар монгол хүний дундаж наслалтыг уртасгах, хүртээмжтэй хөгжлийн хандлагыг зорилт болгосон. Бодлогын зорилтод түвшинд 2026 он гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний 5%-иас доошгүй, улсын төсвийн 12%-иас доошгүй хэмжээний хөрөнгийг эрүүл мэндийн салбарт зориулан зарцуулах, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулах хувь хэмжээг тасралтгүй нэмэгдүүлэх, эрүүл мэндийн нийт зардалд иргэдийн хувиасаа шууд төлөх төлбөрийн эзлэх хэмжээг 25%-иас хэтрүүлэхгүй байлгах, бүх нийтийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах, эх, хүүхэд, нярайн эндэгдлийг 2015 оны хэмжээнээс бууруулах, согтууруулах ундаа, тамхины хэрэглээг багасгах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоог 10%-иас 80% болгон нэмэгдүүлэх, эрүүл мэндийн салбарын цахим нэгтгэсэн системийг бий болгох, болон үр дүнд суурилсан эмнэлгийн санхүүжилтийн системд шилжих зэрэг багтаж байна.

2.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод дараах зорилгыг тусгасан. Үүнд: (i) эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх, (ii) нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, (iii) сайн

засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, (iv) бодлогын хэрэгжилт ил тод, нээлттэй байх, мөн (v) төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах.

3.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого дараах үндсэн чиглэлүүдтэй. Үүнд:

- (i) Нийгмийн эрүүл мэнд
  - (a) хүн амын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах (агаар эсхүл хөрсний бохирдол, хүнсний аюулгүй байдал, хүүхдийг эхийн сүүгээр хооллох гэх мэт.);
  - (b) эрүүл мэндийг дэмжих эсхүл өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэвшлийг дэмжих (согтууруулах ундаа, тамхины хэрэглээг хязгаарлах) үйл ажиллагааг сайжруулах, гэр бүл төлөвлөх, эх хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, шинээр тархаж байгаа халдварт өвчин болон байгалийн гамшгийн үед үзүүлэх яаралтай тусламжийг сайжруулах;
  - (c) нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх, халдварт өвчний тандалт судалгааг сайжруулах; болон
  - (d) гэрээ байгуулах замаар төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагыг оролцуулан хувийн хэвшилд шилжүүлэх.
- (ii) Эрүүл мэндийн чанартай үйлчилгээний хүртээмжийг сайжруулах
  - (a) эмнэлгийн тусламж үйлчилгээг хүн амын нягтрал эсхүл хүн ам зүйн бүтэц, шилжилт, ядуурлын түвшинтэй уялдуулан зохион байгуулах;
  - (b) анхан болон хоёрдогч шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулж үйлчилгээний багцыг өргөжүүлэх;
  - (c) төрийн өмчийн болон хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаар дамжуулах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүргэх;
  - (d) үйлчлүүлэгч төвтэй хандлагыг удирдлага болгон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлийг нэгтгэх;
  - (e) эмнэлгийн яаралтай тусламжийг сайжруулж уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хамтад нь хөгжүүлэх, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулах;
  - (f) төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, мэргэжлийн нийгэмлэгийг байгуулах, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын мэргэжлийн үргэлжилсэн сургалт, нэр хүнд бүхий эрүүл мэндийн байгууллагын эмч, бусад мэргэжилтнүүдээс бүрдсэн



- олон улсын багтай хамтарч ажиллах замаар орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг үргэлжлүүлэн сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх; болон
- (g) гүйцэтгэл эсхүл үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, менежментийн системийг бий болгох (өвчний тархалт, нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах).
- (iii) Эрүүл мэндийн санхүүжилт
- (a) улсын төсвөөс эрүүл мэндийн салбарт зарцуулах зардлыг 12 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 5%-иас доошгүй хэмжээнд хүргэх, анхан шатны тусламж үйлчилгээний (улсын төсвөөс болон эрүүл мэндийн даатгалын сан) зардлыг нэмэх, нэг иргэнд ногдох зардлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөж байгаа түвшинд хүргэх;
- (b) улсын төсвийн орцод тулгуурласан аргыг үр дүн, гүйцэтгэлд чиглэсэн стратегийн худалдан авалтын арга руу шилжүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн шинэчлэлийг үргэлжлүүлэх; болон
- (c) санхүүгийн эх үүсвэрийн ашиглалтыг үр дүн эсхүл чанарт суурилсан байдлаар тайлагнадаг болох, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагын дагуу хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл, технологийн үнэлгээний үр дүн, зөвлөмжийн дагуу эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах.
- (iv) Эрүүл мэндийн технологи
- (a) хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд үндэслэсэн эрүүл мэндийн нэгдсэн цогц системийг бий болгох;
- (b) эрүүл мэндийн технологийн үнэлгээний үр дүн, өвчнийг оношлох орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хүндрэлтэй өвчнийг эмчлэх;
- (c) эрүүл мэндийн судалгаа, эрдэм шинжилгээ эмнэлгийн практикийг нэгтгэх;
- (d) эмнэлэг барих, үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон олон улсын стандартыг боловсруулан мөрдүүлэх;
- (e) эрүүл мэндийн технологийн үнэлгээ, эмнэлгийг хэрэглээний худалдан авалт, эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт, засвар үйлчилгээг сайжруулах болон эрүүл мэндийн технологид оруулах хөрөнгө оруулалтыг ерөнхийд нь болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг тусгайлан дэмжих.
- (v) Мэдээллийн технологи, удирдлага
- (a) үндэсний цахим эрүүл мэндийн архитектурыг хөгжүүлэх, Үндэсний мэдээллийн технологийн төвийг байгуулах;

- (b) өөрийн орны онцлогтой уялдуулан олон улсын мэдээллийн технологийн стандартыг хэрэгжүүлэх;
  - (c) эрүүл мэндийн мэдээлэл солилцох, удирдах үйл ажиллагааг нэгтгэсэн платформыг нэвтрүүлэх; мэдээллийн аюулгүй байдал, нууцлалтай холбогдох хууль эрх зүйн орчныг шинэчлэх; болон
  - (d) үйлчилгээний гүйцэтгэл болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний янз бүрийн шатанд хүн амын эрүүл мэндийн байдалд үзүүлж байгаа үр нөлөөтэй холбогдох мэдээлэлд хяналт шинжилгээ, дүн шинжилгээ болон үнэлгээ хийх боломжийг хангах эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн системийг сайжруулах.
- (vi) Эрүүл мэндийн салбарын засаглал, тогтолцоо
- (a) төрийн өмчит эмнэлгийг хагас бие даасан засаглалтай болгох хууль эрх зүйн орчны шинэчлэл хийх (улс төрийн нөлөөг бууруулах);
  - (b) эрүүл мэндийн салбарын бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулах; болон
  - (c) менежментийн жишиг практикийг нэвтрүүлэх, бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх.

4.ЭМЯ нь 1997 оноос хойш Азийн хөгжлийн банк (АХБ)-наас санхүүжүүлсэн бодлогын болон хөрөнгө оруулалтын зээл, буцалтгүй тусламж, болон техникийн туслалцааны төслийн гүйцэтгэгч байгууллагаар ажиллаж ирсэн. Өнөөдрийн байдлаар, тус салбарт олгосон АХБ-ны нийт санхүүжилт нь 132.55 сая ам.доллар бөгөөд үүнд 84.9 сая ам.долларын таван зээл, 37 сая ам.долларын долоон буцалтгүй тусламж, болон 10.65 сая ам.долларын хэмжээтэй 15 техникийн туслалцаа (цаашид “ТТ”)-ны төсөл багтана.<sup>4</sup> АХБ нь гүйцэтгэгч байгууллагын санхүүгийн болон худалдан авах ажиллагааны чадавхид тогтмол үнэлгээ хийж ирсэн бөгөөд эдгээр үнэлгээгээр ЭМЯ нь АХБ-ны дэмжлэгтэй төслүүдийг удирдан хэрэгжүүлэх чадавхтай болохыг нотолсон. Эрүүл мэндийн салбарт АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн өмнөх хөрөнгө оруулалтууд амжилттай хэрэгжсэн гэж дүгнэгдсэн бөгөөд одоо хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилт сайн байгаа ба 2020 он гэхэд дуусах төлөвлөгөөтэй байна.

5.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх биет хөрөнгө оруулалт нь Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод нийцсэн. Арван загвар өрхийн эрүүл мэндийн төв, зургаан сумын эрүүл мэндийн төв болон дөрвөн дүүрэг/аймгийн нэгдсэн эмнэлэг нь Монгол Улсын эмзэг бүлгийн иргэд оршин суудаг нутаг дэвсгэрт анхан болон хоёрдогч шатны эрүүл мэндийн

<sup>4</sup> АБХ. 2017. Монгол Улс: Эрүүл мэндийн салбарын талаар мэдээлэл. Манила хот.



тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулж, өргөжүүлэхэд чиглэгдэнэ. Яаралтай тусламжийн үйлчилгээний хүлээх хугацааг багасгах, алслагдсан бүс нутагт амьдардаг иргэдэд яаралтай тусламж үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх нь Засгийн газраас эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод нийцнэ.

6. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ (ЭМАШТҮ)-ний төлөвлөлт, төсөвлөлт, зохицуулалт болон хяналт тавихтай холбогдуулан институцийн болон хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэхэд биет бүс хөрөнгө оруулалт зарцуулагдана. Үүнд ЭМЯ-ны системийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах чадавхыг хөгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын төлөвлөлт, гэрээ байгуулах, гэрээний удирдлага, зардлын төлөвлөлт, хөрөнгийн удирдлагатай холбогдох чадавхыг бэхжүүлэх ажлууд багтана. Түүнчлэн, ЭМЯ болон төрийн худалдан авалтын ажиллагааны газар (ТХААГ)-ын худалдан авалт, санхүү, эрсдэлийн удирдлагатай холбогдох чадавхыг бэхжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд өндөр үнийн дүнтэй, том гэрээнүүдийг байгуулахтай болон худалдан авалттай холбоотой эрсдэлийг бууруулах хэрэгцээ шаардлага байгааг Засгийн газар хүлээн зөвшөөрч байгаа болно.

## **В. Стратегийн ач холбогдол**

7. АХБ нь 1997 оноос хойш Монгол Улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж Мянганы хөгжлийн зорилтууд, бүх нийтийг эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах, болон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгасан эрүүл мэндийн салбартай холбогдох үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж ирсэн. 2017 онд Монгол Улс нь бүх нийтийг эрүүл мэндийн даатгалд бараг хамруулсан бөгөөд анхан шатны тусламж үйлчилгээний санхүүжилтийг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн. Эдгээр үр дүн нь АХБ-наас эрүүл мэндийн салбарт оруулсан хөрөнгө оруулалттай шууд холбоотой юм. АХБ-наас оруулсан өмнөх хөрөнгө оруулалт бүрийг амжилттай хэрэгжсэн гэж дүгнэсэн бөгөөд одоо хэрэгжиж байгаа төслүүд нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж 2020 он гэхэд дуусах төлөвлөгөөтэй байна. Өнөөдрийн байдлаар АХБ-ны дэмжлэгээр Улаанбаатар хотын дүүргийн жишиг эмнэлэг байгуулах улмаар дүүргийн түвшинд эмнэлгийн тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн хог хаягдлыг шийдвэрлэх, илүү үр ашигтай ажиллах эмнэлгийн бие даасан удирдлагын тогтолцоог бий болгох зэрэгт дэмжлэг үзүүлж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх талаар эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй реформ анхаарлаа хандуулан ажиллаж ирсэн АХБ-ны туршлага нь хамтран ажиллах түншлэлийн оновчтой хувилбар юм. Энэхүү санал болгож буй хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь АХБ-ны 2030 он хүртэлх стратеги, 2017-2020 оны Монгол Улстай түншлэлийн стратеги,

2019-2021 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө болон 2015-2020 оны Эрүүл мэндийн холбогдох үйл ажиллагааны төлөвлөгөөтэй тус тус нийцэж байгаа болно.<sup>5</sup>

### **С.Бодлогын хүрээ**

8.Төрөөс эрүүл мэндийн талаарх 2017-2026 онуудад баримтлах бодлого нь салбарын хувьд баримтлах бодлогын баримт бичиг юм. Энэхүү бодлогын хүрээнд бүх нийтийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар Монгол хүний дундаж наслалтыг уртасгах зорилтыг тусгасан. Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулиар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрөл, тээдгээрийг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг зохицуулж санхүүжилтийн стратегийг үйлчлүүлэгчдийн оруулах санхүүгийн хувь нэмрийг оролцуулан тодорхойлсон.<sup>6</sup> Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд албан журмын даатгалын хамрах хүрээг тодорхойлж голлох оролцогч талуудын чиг үүргийг зохицуулсан.<sup>7</sup> Түүнчлэн, энэ хуульд эрүүл мэндийн даатгалаар авах үйлчилгээний багцыг тодорхойлсон бөгөөд эмзэг бүлгийн иргэдийг үнэ төлбөргүйгээр эрүүл мэндийн даатгалд хамруулах боломжийг олгосон. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн хүрээ харьцангуй сайн боловсрогдсон боловч эрүүл мэндийн салбарт наалдацтай үр дүн өгөөгүй байна. Төсвийн тухай хуулиар орон нутгийн түвшинд үзүүлэх төрийн эрүүл мэндийн үйлчилгээг зохицуулсан, харин Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу уг салбар дахь бүхий л худалдан авах ажиллагаа явагдаж байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль нь эрүүл мэндийн асуудлаарх бодлогод олон талт оролцогч талуудын оролцоог хангахад чиглэгдсэн байна. Энэхүү өргөн хүрээний бодлогын хүрээ нь эрүүл мэндийн салбарт дорвитой суурь болж буй хэдий ч шинэ сорилтууд үүсэж (ж.нь насжиж буй хүн ам), бодлогын тэргүүлэх чиглэл өөрчлөгдөхийн хэрээр (ж.нь. эрүүл мэндийн даатгал дахь хувийн хэвшлийн оролцоо) өөрчлөлт хийх шаардлагатай болох юм.

### **D.Хөрөнгө оруулалтын хөтөлбөр**

9.Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогод тусгасан

<sup>5</sup> АХБ. 2018. Стратеги 2030: Чинээлэг, хүртээмжтэй, даван туулах чадвартай, тогтвортой Ази-Номхон далайн бүсийг цогцлоох нь. Манила; АХБ. 2018. 2019–2021 онуудад Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнесийн төлөвлөгөө. Манила; АХБ. 2017. АХБ-наас 2017–2020 онуудад Монгол Улстай Хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги— Эдийн засгийн хүндрэлийн үед хүртээмжтэй өсөлтийг хангах нь. Манила; АХБ. 2015. Эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө, 2015–2020: Ази-Номхон далайн бүсийн эрүүл мэнд—АХБ-ны хөгжиж буй гишүүн орнуудын эрүүл мэндийн хэрэгцээ хангахад баримтлах төвлөрсөн арга барил. Манила

<sup>6</sup> Улсын Их Хурал. 2016. Эрүүл мэндийн тухай хууль. Улаанбаатар хот.

<sup>7</sup> Улсын Их Хурал. 2016. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль. Улаанбаатар хот.



алсын хараа, зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт биет болон биет бус хөрөнгө оруулалтыг тусгасан. Биет хөрөнгө оруулалтаар эрүүл мэндийн анхан болон хоёрдогч шатны үйлчилгээний зорилтуудыг хангахад үүсэж буй бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд чиглэгдэх бол биет бус хөрөнгө оруулалт нь уг салбарын институцийн чадавхын хөгжил болон санхүүгийн тогтвортой байдал, бодлого зохицуулалтын хүрээг хөгжүүлэхэд чиглэгдэх юм. Эдгээр хөрөнгө оруулалтыг хийх төсвийн орон зай бий болгосноор Засгийн газар нь чанартай бөгөөд хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

10. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь дээр дурдсан үндсэн асуудлуудыг шийдвэрлэх дөрвөн гол үр дүнг авчирна. Үүнд: (i) хот болон хөдөөгийн ЭМАШТҮ бэхжих, (ii) аймаг, дүүргийн эмнэлгийн үйлчилгээ сайжрах, (iii) эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоо сайжрах, болон (iv) холбогдох төрийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагаа болон санхүүгийн менежмент сайжрах. Арван жилийн хугацаанд хэрэгжих энэхүү хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг гурван төсөлд хуваасан болно. Гурван төслийн хүрээнд хүрэх үр дүн тус бүрийн хувьд хэрэгжүүлэх үйл ажиллагааг Хүснэгт 1-д харуулсан.

Хүснэгт 1: Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн ба төслүүдээр

Зориулалт	Төсөл 1 (2019–2025)	Төсөл 2 (2022–2026)	Төсөл 3 (2025–2029)
Бүтээгдэхүүн 1: Хот болон хөдөөгийн ЭМАШТҮ-г бэхжүүлэх			
Хөрөнгө оруулалт (биет)	Улаанбаатар хотод НХХБЯТ <sup>а</sup> ашиглан дөрвөн ӨЭМТ байгуулах	Сонгогдсон нэг сумд СЭМТ байгуулах	Улаанбаатар хотод зургаан ӨЭМТ байгуулах
	Сонгогдсон сумдад таван СЭМТ байгуулах		
	Улаанбаатар хотод ЯТҮТ байгуулах		
Шинэчлэл/ чадавхыг бэхжүүлэх	ЭМАШТҮ-ний санхүүжилт, хүний нөөц, гэрээлэлт болон чанарын удирдлагын шинэчлэл		
	Анхан болон хоёрдогч шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс тэдгээр хоорондын уялдааг хангасан цогц үйлчилгээний загварыг хэрэгжүүлэх		



	Эмнэлгийн барилга болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ТХХТ-н загварыг нэвтрүүлэх		
	ЭМАШТУ-ний төлөвлөлт, төсөвлөлт, зохицуулалт болон хяналтын чиглэлээр НЭМГ болон аймгийн эрүүл мэндийн газрын институцийн шинэчлэл хийх		
	Үндэсний хэмжээнд яаралтай тусламжийн тогтолцоог боловсруулж хэрэгжүүлэх		
<b>Бүтээгдэхүүн 2: Аймаг, дүүргийн эмнэлгийн үйлчилгээг сайжруулах</b>			
Хөрөнгө оруулалт (биет)	Хан-Уул дүүргийн НЭ-ийг НХХБЯТ <sup>2</sup> -ийг ашиглан өргөтгөн шинэчлэх	Хан-Уул дүүргийн НЭ-н өргөтгөл, шинэчлэл -үргэлж.	Чингэлтэй дүүргийн НЭ-ийг шинээр байгуулах – үргэлж.
	Ховд аймгийн НЭ-ийг өргөтгөн шинэчлэх	Чингэлтэй дүүргийн НЭ-ийг шинээр байгуулах	
	Увс аймгийн НЭ-ийг өргөтгөх		
Шинэчлэл/ чадавхыг бэхжүүлэх	Эмнэлгийн бие даасан байдлыг хөгжүүлэх институцийн болон чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх		
	Төслийн эмнэлгүүдийн удирдлагын багийн чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх		
	Эмнэлгийн барилга болон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ТХХТ-н загварыг нэвтрүүлэх		
<b>Бүтээгдэхүүн 3: Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх</b>			
Шинэчлэл/ чадавхыг бэхжүүлэх	Стратегийн худалдан авалтын тогтолцооны загвар, эрх зүйн зохицуулалт, замын зураглалыг боловсруулах		
	СЯ, ЭМЯ болон ЭМДБ-д стратегийн худалдан авалтын манлайлал, төлөвлөлт, бодлогын уялдаа зохицуулалтыг сайжруулах чиглэлээр институци болон чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх		





	<p>ЭМЯ-нд системийн гүйцэтгэлийн дүн шинжилгээ, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын чиглэлээр институци болон чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх</p>		
	<p>ЭМДБ-д сангийн менежмент, гэрээлэлт, гэрээний менежмент, өртөг тооцох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын мониторинг хийх институци болон чадавх бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх</p>		
<p><b>Бүтээгдэхүүн 4: Төрийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагаа болон санхүүгийн менежментийн чадавх сайжирсан байх</b></p>			
<p>Шинэчлэл мөн/ эсхүл чадавхыг бэхжүүлэх</p>	<p>СЯ, ЭМЯ, Төрийн худалдан авах агентлагт худалдан авах ажиллагаа, санхүүгийн болон эрсдэлийн менежментийн чиглэлээр институци болон чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулах</p>		

ӨЭМТ = өрхийн эрүүл мэндийн төв, ЭМДБ = эрүүл мэндийн даатгалын байгууллага, НХХБЯТ = нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг технологи, СЯ= Сангийн яам, ЭМЯ = Эрүүл мэндийн яам, ЯТҮТ= Яаралтай тусламжийн үндэсний төв, ЭМАШТҮ = эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, ТХХТ = төр, хувийн хэвшлийн түншлэл, СЭМТ = сумын эрүүл мэндийн төв, НЭМГ = Нийслэлийн Эрүүл мэндийн газар.

<sup>a</sup> Хан-Уул дүүргийн эмнэлэг, сонгогдсон гурван ӨЭМТ-д НХХБЯТ-ийг ашиглана.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банкны тооцоо.

11. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн өртөг нь татвар, хураамж, магадлашгүй зардал болон үнийн болзошгүй өөрчлөлт, хүү болон бусад шимтгэлийг оролцуулан хэрэгжүүлэх хугацаанд нийт 163.51 сая ам.доллар байна. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зардлын тооцооллыг Хүснэгт 2-т харуулав.

## Хүснэгт 2: Зардлын тооцооллын хураангуй (сая ам.доллар)

Зориулалт	Дүн <sup>а</sup>
<b>А. Суурь зардал<sup>б</sup></b>	
1. Бүтээгдэхүүн 1: хот болон хөдөөгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх	33.33
2. Бүтээгдэхүүн 2: аймаг, дүүргийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах	100.45
3. Бүтээгдэхүүн 3: эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх	4.21
4. Бүтээгдэхүүн 4: холбогдох төрийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагаа болон санхүүгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх	3.24
<b>Дэд нийлбэр (А)</b>	<b>141.23</b>
<b>В. Магадалшгүй зардал<sup>с</sup></b>	<b>13.79</b>
<b>С. Хэрэгжилтийн явцад тооцох санхүүжилтийн төлбөр<sup>д</sup></b>	<b>8.49</b>
<b>Нийт (А+В+С)</b>	<b>163.51</b>

<sup>а</sup> 1.69 сая ам.долларын татвар, хураамжийг оролцуулан тооцсон ба Засгийн газар түүнээс чөлөөлөх хэлбэрээр санхүүжүүлнэ. Энэхүү дүн нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зардлын томоохон хэсгийг эзлэхгүй болно.

<sup>б</sup> 2018 оны 11 дүгээр сарын үнэ.

<sup>с</sup> Барилгын ажлын болоод хээрийн судалгаа ба хөгжил, сургалт, судалгаа болон үнэлгээний магадалшгүй зардлыг 5% гэж тооцсон. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үнийн магадалшгүй зардлыг гадаад валютын зардлын хувьд 1.8%, дотоодын валютын зардлын хувьд 2.5% гэж тооцсон бөгөөд худалдан авах чадварын квотын ханшийн таамаглалд үндэслэн ханшийн хэлбэлзлийн боломжит эрсдэлийн нөөцийг тооцон оруулав.

<sup>д</sup> Үүнд бүх эх үүсвэрт хамаарах хүүгийн төлбөр, хариуцлагын хураамж болон бусад санхүүжилтийн шимтгэлийг оруулж тооцов. Барилгын ажлын явцад энгийн эх үүсвэр (ЭЭҮ)-ийн хүүг тооцоолохдоо 5 жилийн ам.долларын тогтмол своп хүү, хүчин төгөлдөр гэрээний хүү 0.5% болоод хугацааны шимтгэл 0.2%-ийн нийлбэрийг ашиглав. Зарцуулагдаагүй зээлийн дүнд тооцогдох ЭЭҮ-ийн хөрөнгө баталгаажуулсны төлбөр 0.15% байна. Хөнгөлөлттэй ЭЭҮ-ийн зээлийн хүү жилийн 2% байна.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банкны тооцоо.

### **Е.Санхүүжүүлтийн төлөвлөгөө**

12. Засгийн газраас Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор 158.34 сая ам.доллартай тэнцэх санхүүжилт бүхий ҮШСС авах хүсэлт гаргасан. Хөтөлбөр нь гурван үе шаттай бөгөөд санхүүжилт



олгогдох эсэх нь Засгийн газраас үечилсэн санхүүжилтийн хүсэлт гарган, холбогдох зээлийн болон буцалтгүй тусламжийн хэлэлцээрийг байгуулсан, СЕХ-т тусгагдсан нөхцөл, болзол болоод агуулгын хувьд мөрдлөг болгосон эсэхээс хамаарах бөгөөд энгийн, хөнгөлөлттэй зээл болон хамтран санхүүжилтийн буцалтгүй тусламжийн эх үүсвэрээс бүрдэнэ. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр. Эхний үе шат нь зээлийн 66.14 сая ам.долларын энгийн зээл, 10.00 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл болно. Энгийн эх үүсвэрийн зээл нь 25 жилийн хугацаатай байх ба эхний 6 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Зээлийн хүү нь АХБ-ны Лондонгийн банк хоорондын зээлийн хүү (LIBOR) байх ба хөрөнгө баталгаажуулсны төлбөр болох 0.15%, барилгын ажлын явцад зээлийн хүү болон бусад шимтгэлийг зээлийн үндсэн дүнд нэмэгдэж тооцогдох бөгөөд зээлийн хэлэлцээрийн төсөлд тусгагдсан бусад нөхцөл, болзлоос бүрдэнэ. Шулуун шугамын аргачлалын дагуу зээлийн дундаж хугацаа нь 15.75 жил байх ба шимтгэл 0.10% байна. Хөнгөлөлттэй зээл нь 25 жилийн хугацаатай, эхний 5 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх ба жилийн хүү 2%, барилгын ажлын явцад зээлийн хүү болон бусад шимтгэлийг зээлийн үндсэн дүнд нэмэгдэж тооцох, бөгөөд зээлийн хэлэлцээрийн төсөлд тусгагдсан бусад нөхцөл, болзлоос бүрдэнэ.

13. Эхний үе шатаар эрүүл мэндийн төвийн барилгын ажил, эмнэлгийн болон мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, Яаралтай түргэн тусламжийн үндэсний төвийн агаарын тээвэрлэлт, зөвлөх үйлчилгээ болон чадавхыг бэхжүүлэх асуудлуудад санхүүжилт хийнэ. Засгийн газар нь нийт татвар, хураамж, ашиглалтын 1.69 сая ам.доллар санхүүжүүлэх ба Харилцан кредит олгох механизмын Японы сангаас санал болгож буй, АХБ-наас захиран зарцуулах 3.48 сая ам.доллартай тэнцэх буцалтгүй тусламж нь НХХБЯТ Үе шат 1-т зориулагдсан. Энэ нь ба засвар үйлчилгээний зардалд зориулагдана. Харилцан кредит олгох механизмын Японы сангийн буцалтгүй тусламж нь хамтарсан санхүүжилт байдлаар гарна.

14. Эхний үе шатны хамрах хүрээ. Бүтээгдэхүүн 1-ийн хүрээнд дараах үйл ажиллагаа хамаарна, үүнд: (i) нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг технологи<sup>8</sup> ашиглан Улаанбаатар хотын ядуурал ихтэй гэр хороололд дөрвөн өрхийн эрүүл мэндийн төв (ӨЭМТ), таван сумын эрүүл мэндийн

<sup>8</sup> Эрүүл мэндийн байгууламжуудын дулааны алдагдал багасгах үүднээс нэвтрүүлж буй нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг технологийг ХКТМЯС-гаас санхүүжүүлнэ.

төв (СЭМТ) байгуулах; (ii) телемедицин болон агаарын үйлчилгээнд тулгуурласан яаралтай тусламжийн үндэсний системийг нэвтрүүлэх, (iii) нийслэлийн болон аймгийн эрүүл мэндийн газруудад ЭМАШТҮ-ний санхүүжилт, хүний нөөц, гэрээлэлт чанарын удирдлагын шинэчлэл хийх чадавх хөгжүүлэх; (iv) нэг болон хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн үйлчилгээний нэгдсэн загварыг хэрэгжүүлэх, мөн (v) эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд төр хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) загварыг хэрэгжүүлэх болно. Бүтээгдэхүүн 2-ын хүрээнд дараах үйл ажиллагаа хамаарна, үүнд нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг технологи ашиглан Хан-Уул дүүргийн эмнэлгийг өргөтгөж шинэчлэх, Ховд, Увс аймгийн эмнэлгийг өргөтгөх; эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх; мөн ТХХТ-ийн загварыг хэрэгжүүлэх болно. Бүтээгдэхүүн 3-ын хүрээнд эрүүл мэндийн санхүүжилтийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлж, эрүүл мэндэд иргэд хувиасаа гаргах зардлыг бууруулах үүднээс стратегийн худалдан авалтын загварын эрх зүйн орчин болон замын зураглалыг боловсруулна.<sup>9</sup> Бүтээгдэхүүн 4-ийн хүрээнд ЭМЯ болон ТХААГ-ын худалдан авах ажиллагаа, санхүү болон эрсдэлийн удирдлагын чадавхыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Нэгдүгээр үе шатны төсөл нь 2 болон 3 дугаар үе шатны төслүүдийн хүрээнд үргэлжлэх ба үе шат тус бүрийн бэлтгэл ажлыг өмнөх төслийн хүрээнд хангана.

**15. Хоёрдугаар болон гуравдугаар үе шатны хамрах хүрээ.** Төсөл 2 болон 3 нь Үе шат 1-ийн хүрээнд хийх хөрөнгө оруулалтын үргэлжлэл байх юм. Эдгээр үе шатуудад Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт шинэ эмнэлэг байгуулахын сацуу ЭМТ-ийн тоог зургаа, СЭМТ-ийн тоог нэгээр нэмэгдүүлнэ. ЭМАШТҮ-ний санхүүжилт болон бүтэц зохион байгуулалтын шинэчлэл, тусламж үйлчилгээний тасралтгүй цогц байдал, ТХХТ-ийн загварын хэрэгжилт болон НЭМГ-ыг бэхжүүлэх ажлуудыг хэрэгжүүлнэ. Түүнчлэн стратегийн худалдан авагчийн институцийг бий болгох бөгөөд ЭМЯ болон ТХААГ-ын чадавхыг үргэлжлүүлэн бэхжүүлнэ.

<sup>9</sup> Стратегийн худалдан авалт гэж үйлчилгээ үзүүлэгчдээс эрүүл мэндийн үйлчилгээг идэвхтэй, нотолгоонд суурилсан байдлаар худалдан авахыг хэлэх ба ингэхдээ эрүүл мэндийн тэргүүлэх чиглэл, зардлын үр-ашигт байдал, үйлчилгээний зохистой хэм хэмжээ мөн үйлчилгээ үзүүлэгчийн хослол (төрийн, хувийн хэвшил)-д тулгуурлан нийгмийн эрх ашгийг дээд түвшинд байлгахаар худалдан авахыг хэлнэ. Тусламж үйлчилгээ худалдан авагч нь эрүүл мэндийн даатгалын байгууллага (жишээ нь Япон, Герман, Нидерланд) эсхүл Засгийн газар (жишээ нь Англи, Итали) байж болно.

**ХУВААРЬ 2**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ХҮРЭЭ**

<b>Хөрөнгө оруулалтын үр нөлөө нь</b> Монгол хүний эрүүл мэндийг сайжруулах (Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, 2017–2026) <sup>a</sup>			
<b>Үр дүнгийн хэлхээ</b>	<b>Суурь болон хүрэх түвшин бүхий гүйцэтгэлийн үзүүлэлт</b>	<b>Мэдээллийн эх үүсвэр ба тайлагналт</b>	<b>Эрсдэл</b>
<b>Үр дүн</b>	<b>2030 он гэхэд</b>		
Ховд, Увс аймаг болон Улаанбаатар хотын гэр хороолол, бусад сонгогдсон сумдад иргэдийн орлогод нийцсэн, чанартай эрүүл мэндийн анхан болон хоёрдогч шатны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	<p><b>а.</b> Төслийн аймаг дүүргүүдэд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн суурь тусламж үзүүлчлгээг стандартын түвшинд үзүүлэх чадавх 50%-иар нэмэгдсэн байх (2017 он суурь түвшин: Хан-уул, Чингэлтэй дүүрэгт тусламж үйлчилгээний бэлэн байдлын индекс 61.5%)</p> <p><b>б.</b> Төслийн аймаг дүүргүүдэд хоёрдогч шатны тусламж үйлчилгээний хүрээ нэр төрлийн талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байх (2019 суурь түвшин: судлагаа хийгдэнэ <sup>b</sup>)</p> <p><b>с.</b> Улсын төсөөс санхүүжих эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 20%-г ЭМДБ-аар гэрээлсэн байна (2019 суурь түвшин: 0%)</p>	<p><b>а.</b> Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын аргачлалаар тусламж үйлчилгээний бэлэн байдлын үнэлгээний тайлан</p> <p><b>б.</b> Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн талаарх төслийн судалгааны тайлан</p> <p><b>с.</b> ЭМЯ болон СЯ-ны жилийн тайлан</p>	Хөтөлбөрийн хөрөнгө оруулалт болон үйл ажиллагаанаас үүдэн бий болох эмнэлэг, эрүүл мэндийн барилга байгууламж болон яаралтай тусламжийн үйлчилгээний ашиглалт, засвар зардлыг дугуу төсөвлөх
<b>Бүтээгдэхүүн</b>	<b>2028 он гэхэд</b>		
1. Хот болон хөдөөгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж	1а. Улаанбаатар хотод жендэрийн мэдрэмжтэй, үйлчлүүлэгчид ээлтэй өргөтгөсөн үйлчилгээ бүхий 10 ӨЭМТ байгуулагдсан байх	1а-с. ЭМЯ-ны жил бүрийн төслийн явцын тайлан	Төрөөс санхүүжүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ЭМДБ-гаар

<p>үйлчилгээг бэхжүүлэх</p>	<p>с (2017 он суурь түвшин: 129 ӨЭМТ) 1б. Сонгогдсон аймгуудад жендэрийн мэдрэмжтэй, үйлчлүүлэгчид ээлтэй 6 СЭМТ байгуулагдсан байх (2017 он суурь түвшин: 312 СЭМТ)<sup>с</sup> 1с. Эрүүл мэндийн анхан болон хоёрдогч шатны тусламж үйлчилгээг уялдуулах загварыг Улаанбаатар хотын 5 дүүрэг болон 10 аймагт хэрэгжүүлсэн байх (2019 он суурь түвшин: Х-гүй) 1д. НХХБЯТ-ийг 3 ӨЭМТ-д суурилуулсан байх (2019 он суурь түвшин: Х-гүй) <b>2026 он гэхэд</b> 1е. ӨЭМТ-ийн засвар, тусламж үйлчилгээнд ТХХТ-н загварыг туршин үр дүнг үнэлсэн байх (2019 он суурь түвшин: Х-гүй)</p>	<p>1д. Мониторинг ба баталгаажуулалтын тайлан 1е. Төслийн тайлан</p>	<p>дамжуулан эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэгчээс худалдан авахыг эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид болон төрийн ажилтнууд эсэргүүцэх</p>
<p>2. Аймаг, дүүргийн эмнэлгийн үйлчилгээг сайжруулах</p>	<p><b>2026 он гэхэд</b> 2а. Цингэлтэй дүүрэгт жендэрийн мэдрэмжтэй загвар дүүргийн эмнэлгийг байгуулсан байх (2019 он суурь түвшин: Х-гүй)<sup>д</sup> 2б. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн эмнэлгийг өргөтгөж, мэс засал, эх барих, эмнэлгччүүд болон бусад үйлчилгээг нэвтрүүлж, хэвтэн эмчлүүлэх болон амбулаторийн үйл ажиллагааг уялдуулсан байх (2019 он суурь түвшин: Х-гүй) 2с. Ховд аймгийн эмнэлгийг шинэ оношилгоо, эмчилгээний төвтэй болгож өргөтгөсөн байх (2019 он суурь түвшин: Х-гүй)</p>	<p>2а-д. Төслийн тайлан, ЭМЯ-ны жилийн тайлан</p>	



	<p><b>2024 он гэхэд</b> 2d. Увс аймгийн эмнэлгийг амбулаторийн шинэ тасагтай болгож өргөтгөсөн байх (2019 он суурь түвшин: Х-гүй)</p>		
	<p><b>2029 он гэхэд</b> 2e. Аймаг, дүүргийн эмнэлгийн 50% нь ЭМЯ-наас баталсан журмын дагуу бие даасан байдалтай үйл ажиллагаа явуулж байх (2019 он суурь түвшин: 0)</p>	<p>2e. Эмнэлгийн бие даасан байдлыг зохицуулах ЭМЯ-ны журам баталсан талаар судалгаа</p>	
	<p>2f. Эмнэлгийн удирдах ажилтны 50% (тэдгээрийн 50% нь эмэгтэй) эмнэлгийн удирдлагын чиглэлээр ур чадвар сайжирсан гэж мэдээлэх (2019 он суурь түвшин: 0)</p>	<p>2f-h. Оролцогчдын санал, үнэлгээний үр дүн болон ур чадварын шалгалт</p>	
	<p>2g. Өрхийн эмч нар болон бусад холбогдох ажилтны 80%, (тэдгээрийн 50% нь эмэгтэй) жөндөрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй болж тусламж үйлчилгээ үзүүлдэг байх (2019 он суурь түвшин: 0)</p>		
	<p>2h. Зардал багатай, нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрийг Хан-уул дүүргийн эмнэлэгт суурилуулсан байх (2019 он суурь түвшин: 0)</p>		
<p>3. Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулах</p>	<p><b>2029 он гэхэд</b> 3a. Батлагдсан журмын дагуу ЭМДГ, СЯ, ЭМЯ болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг хамруулсан стратегийн нэгдсэн худалдан авалтын загварыг нэвтрүүлсэн байх (2019 он суурь түвшин: Х-гүй)</p>	<p>3a. Сайдын тушаал, ЭМЯ болон СЯ-ны тайлан</p>	

	<p>3в. ЭМДБ-ын ажилтны 80% нь төлөвлөх, хэлэлцээр хийх, гэрээлэх болон гэрээний менежмент, өртөг тооцох, мониторинг ба тайлагнал, үйлчилгээний чанарын хяналт болон сангийн менежмент гэж зэргээр ур чадвар, чадавх сайжирсан гэж тайлагнасан байх (2019 он суурь түвшин 0%)</p> <p>3с. ЭМЯ болон СЯ-ны ажилчдын 80% (эдгээрийн 50% нь эмэгтэй) манлайлал, төлөвлөлт болон худалдан авалтын ур чадвараа сайжруулсан гэж мэдээлэх (2019 оны суурь түвшин: 0)</p>	<p>3б. Сургалтанд оролцогчдын судалгаа</p> <p>3с. Сургалтанд оролцогчдоос авсан судалгаа</p>
<p>4. Төрийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагаа болон санхүүгийн менежментийн чадавх сайжирсан байх</p>	<p><b>2024</b> он гэхэд</p> <p>4а. ЭМЯ-ны ажилчдын 60% нь худалдан авах ажиллагаа, санхүү болон эрсдэлийн удирдлагын чадавхаа сайжруулсан гэж мэдээлэх (2019 он суурь түвшин: 0)</p>	<p>4а. Оролцогчдын санал, үнэлгээний үр дүн болон ур чадварын шалгалт</p>
<p><b>Гол үйл ажиллагаа болон үр дүнгийн хамт</b></p> <p><b>1. Аймаг, дүүргийн эмнэлгийн үйлчилгээг сайжруулсан байх</b></p> <p>1.1 ЭМАШТУ-ний түвшинд шинэчлэл хийх, үндэс санхүүжилт (ЭМАШТУ болон эмнэлгийн санхүүжилтийг тэнцвэржүүлэх), хүний нөөц, засвар үйлчилгээ, үйлчилгээний зохион байгуулалт болон чанарын удирдлага хамаарна (Үе шатууд 1–3, 2019–2028)</p> <p>1.2 Улаанбаатар хотын ядуурал ихтэй хэсэгт жендэр болон үйлчлүүлэгчид ээлтэй 10 загвар ЭӨМТ-ийг (зарим сонгогдсон ЭӨМТ-д НХХБЯТ ашиглана) шинээр байгуулж, эмэгтэйчүүд, лаборатори болон оношилгооны үйлчилгээ болон клиникийн хүрч үйлчлэх үйлчилгээ гэх зэргээр үйлчилгээг өргөтгөх (Үе шатууд 1–3, 2019–2028)</p> <p>1.3 Сонгогдсон аймгуудад жендэр болон үйлчлүүлэгчид ээлтэй 6 СЭМТ шинээр барих бөгөөд зарим СЭМТ-д НХХБЯТ ашиглана (Үе шатууд 1–2, 2019–2026)</p> <p>1.4 Анхан болон хоёрдогч шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс тэдгээр хоорондын уялдааг хангасан цогц үйлчилгээний загварыг боловсруулж, хэрэгжүүлэх (Үе шатууд 1–3, 2019–2028)</p> <p>1.5 ЭӨМТ-ийн менежментийг сайжруулах үүднээс засвар үйлчилгээ болон үйлчилгээ хүргэлтэд дор хаяж нэг ТХХТ-ийн загварын хэрэгжих боломжийг судалж, зөвлөмж гаргаж, тодорхойлж, хэрэгжүүлэх (ж.нь., Тонго төхөөрөмжийн зардал хуваах, нийгмийн франчайзинг) (Үе шатууд 1–3, 2019–2028)</p>		



- 1.6. Одоогийн яаралтай тусламжийн нөхцөл байдлыг үнэлж, яаралтай тусламжийн үндэсний тогтолцооны дизайныг боловсруулж, хэрэгжүүлэх (Үе шат 1, 2019–2024)
- 1.7. ЭМАШТУ-ний төлөвлөлт, төсөвлөлт, зохицуулалт, хяналттай холбоотой НЭМГ болон аймгийн эрүүл мэндийн газрын сургалтын хэрэгцээнд тулгуурлан, мэдээллийн технологид тулгуурласан институцийн болон хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Үе шатууд 1–2, 2019–2026)
2. Аймаг, дүүргийн эмнэлгийн үйлчилгээг сайжруулсан байх
  - 2.1 Хан-Уул дүүргийн эмнэлгийг Сонгинохайрхан дүүргийн загварт түшиглэн өргөтгөх, үндэс зураг төсөв, барилга угсралт, тоног төхөөрөмжийн хангалт, ажилтны сургалт болон НХХЯБТ гэх зэрэг хамаарна (Үе шатууд 1–2, 2019–2026)
  - 2.2 Ховд аймгийн эмнэлгийг өргөтгөж, оношилгоо, эмчилгээний төв байгуулах ба үндэс зураг төсөв, барилга угсралт, тоног төхөөрөмжийн хангалт, ажилтны сургалт болон НХХЯБТ гэх зэрэг хамаарна (Үе шатууд 1–2, 2019–2026)
  - 2.3 Увс аймгийн эмнэлэгт шинэ амбулаторийн тасаг нээж өргөтгөх ба үндэс зураг төсөв, барилга болон ажилтны сургалт гэх зэрэг хамаарна (Үе шат 1, 2019–2024)
  - 2.4 Чингэлтэй дүүргийн загвар эмнэлгийг Сонгинохайрхан дүүргийн загварт түшиглэн өргөтгөх, үндэс зураг төсөв, барилга угсралт, тоног төхөөрөмжийн хангалт, ажилтны сургалт болон НХХЯБТ гэх зэрэг хамаарна (Үе шатууд 2–3, 2022–2029)
  - 2.5 Бие даасан эмнэлгийн менежментийн системийн үргэлжлүүлэн хөгжүүлэх, тохиролцсон менежментийн системд үндэслэн эмнэлгийн бие даасан, хараат бус байдлыг дэмжих чадварыг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх (Үе шатууд 1–3, 2019–2028)
  - 2.6 Эмнэлгийн менежментийг сайжруулах үүднээс засвар үйлчилгээ болон үйлчилгээ хүргэлтийн ТХХТ-ийн загварыг зөвлөж, хэрэгжүүлэх (ж.нь., тоног төхөөрөмжийн зардал хуваалцах) (Үе шатууд 1–3, 2019–2028)
  - 2.7 Төсөлд хаиргагдах эмнэлгийн удирдлагын баг болон бусад холбогдох оролцогч талуудад эмнэлгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх (Үе шатууд 1–3, 2020–2028)
  - 2.8 Эрүүл мэндийн байгууллагад НХХБЯТ суурилуулж, хяналт тавих (Үе шатууд 1–3, 2020–2029)
3. **Эрүүл мэндийн санхүүжилтийн системийг сайжруулсан байх**
  - 3.1 Стратегийн худалдан авалтын загварыг боловсруулж Улсын төсвөөс санхүүжүүлдэг эрүүл мэндийн зарим тусламж үйлчилгээг ЭМДБ-аар даажуулан худалдан авах, санхүүжилтийг шилжүүлэх журам батлан хэрэгжүүлэх (Үе шатууд 1–3, 2019–2027)
  - 3.2 Стратегийн худалдан авалтын чиглэлээр манлайлал, төлөвлөлт, бодлогын уялдаа зохицуулалтыг сайжруулах үүднээс СЯ эсхүл ЭМЯ болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд институт болон чадавх бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх (Үе шатууд 1–3, 2019–2026)
  - 3.3 Системийн гүйцэтгэлийн дүн шинжилгээ, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын чиглэлээр институт болон чадавх бэхжүүлэх хөтөлбөр ЭМЯ-нд боловсруулж, хэрэгжүүлэх (Үе шат 2, 2022–2026)
  - 3.4 Сангийн менежмент, гэрээлэлт, гэрээний менежмент, өртөг тооцох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын мониторинг хийх институт болон чадавх бэхжүүлэх хөтөлбөр ЭМДБ-д боловсруулж, хэрэгжүүлэх (Үе шатууд 1–3, 2019–2029)
4. **Төрийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагаа болон санхүүгийн менежментийн чадавх сайжирсан байх**
  - 4.1 Холбогдох төрийн байгууллагад дотоод процессийг үнэлж, худалдан авах ажиллагаа, санхүү болон эрсдэлийн удирдлагын процедурын чиглэлээр институт болон чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх (Үе шатууд 1–3, 2019–2028)
  - 4.2 АХБ-ны шинэ худалдан авах ажиллагааны, санхүү болон эрсдэлийн удирдлагын процедурын чиглэлээр ЭМЯ-ны чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа тогтмол явуулах (Үе шатууд 1–3, 2019–2028)

<p>Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ, үүнд: (i) иргэдийн хувьнасаа гаргаж буй зардлын судалгаа, (ii) эмнэлгийн бие даасан үйл ажиллагаа ба менежментийн үнэлгээ, (iii) эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ашиглалтын судалгаа, болон (iv) стратегийн худалдан авалтыг нэвтрүүлснээр эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг судлах урт хугацааны судалгаа.</p> <p><b>Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үе шат 2 ба 3-ыг магадлан судалгааны хамт бэлтгэх</b></p> <p>(2021 он гэхэд II үе шат; 2024 он гэхэд III үе шат)</p> <p>Худалдан авах ажиллагааг явуулж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах.</p> <p>Барилгын ажил болон эрүүл мэндийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хянах.</p> <p>Дараахыг хэрэгжүүлж, тайлагнана, үүнд (i) нийгэм ба жэндэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон (ii) байгаль орчны менежмент ба уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах төлөвлөгөө.</p> <p><b>Орц</b></p> <p>Азийн Хөгжлийн Банк: 158.34 сая ам.доллар (зээл)</p> <p>Харилцан Кредит Олгох Механизмын Японы Сан: 3.48 сая ам.доллар</p> <p>Засгийн газар: 1.69 сая ам.доллар</p> <p>Бусад санхүүжүүлэгч туншүүд</p> <p>Хамааралгүй</p>
--

ЭМТ = өрхийн эрүүл мэндийн төв, ЭМДБ = Эрүүл мэндийн даатгалын байгууллага, НХХБЯТ = нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг технологи, СЯ = Сангийн яам, ЭМЯ = Эрүүл мэндийн яам, Х-гүй = хамааралгүй, ЭМАШТУ = Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, ТХХТ = төр, хувийн хэвшлийн түншлэл, СЭМТ = сумын эрүүл мэндийн төв, НЗДТГ = Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, НЭМГ = Нийслэлийн эрүүл мэндийн газар.

а Монгол Улсын Засгийн газар. 2016. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, 2017–2026. Улаанбаатар хот.

б Эрүүл мэндийн хоёрдогч үйлчилгээ гэдэг нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэх үйлчилгээг хэлнэ.

с Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн суурь судалгааг 2019 онд хийнэ.

д Үзүүлэлт 1а болон 1b-ийн жэндэрийн мэдрэмжтэй гэдэгт эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээнд чиглэгдсэн (i) эмэгтэйчүүдийн суурь тусламж, оношилгоо (Пап-тест, хэт авиа) болон СЭМТ-д эх барихын тусламж үйлчилгээ, (ii) эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээ гэх мэт жэндэрийн өвөрмөц хэрэгцээнд сургагдсан мэргэжилтэн, (iii) зохих тоног төхөөрөмж болон (iv) өвчтөний хувийн тусгаар байдлыг хангах зэрэг үйлчилгээ хамаарна.

е Загвар эмнэлэг гэдэг нь Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх төсөл дөрөвийн хүрээнд баригдаж буй Сонгино хайрхан дүүргийн загвар эмнэлгийн загварт суурилдана. Тус эмнэлэг нь (i) 2011 оны Эрүүл мэндийн тухай хуулинд заасан мөс засал, төрөх хавдар болон яаралтай тусламж гэх зэрэг төрөлжсөн олон үйлчилгээтэй, (ii) амбулаторийн болон хэвтүүлж эмчлэх үйлчилгээг уялдуулсан, (iii) дэвшилтэд лаборатори, оношилгоо, болон (iv) сайжирсан эмнэлгийн менежментийг нэвтрүүлнэ.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк.



## ХУВААРЬ 3

### ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ

#### **А. Гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч байгууллагууд:**

1.Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн гүйцэтгэгч байгууллага нь ЭМЯ болно. ЭМЯ нь бүтээгдэхүүн 1,2,3 болон 4, Ховд аймаг, Увс аймаг болоод бусад сонгогдсон сумдын хөрөнгө оруулалтын хувьд хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллана. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Улаанбаатар хотын хөрөнгө оруулалтын хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллана. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (буюу Төрийн худалдан авах ажиллаганы газар) нь Хан-Уул дүүргийн эмнэлэг, Ховд болон Увс аймгийн эмнэлэг, Чингэлтэй дүүргийн эмнэлгийн барилгын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг хүлээж буй болно.

2. Хөтөлбөрийн удирдах хороог ЭМЯ даргалах (дарга) бөгөөд дараах байгууллагуудын төлөөллийг хангасан байна: СЯ, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Өрхийн эмчийн холбооны нэг төлөөлөгч, аймгийн эрүүл мэндийн газрын нэг төлөөлөгч, улсын эмнэлэг болон мэргэшсэн төвүүдийн нэг төлөөлөгч болон дүүргийн эмнэлгийн нэг төлөөлөгч. АХБ-ны шаардлагад нийцсэн дээр дурдсан байгууллагуудын эрх, үүргийг залгамжлагч аливаа байгууллагууд ХУХ-нд мөн гишүүнээр ажиллана.

#### **В.Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хяналт тавих**

3.АХБ нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг үнэлэх зорилгоор үнэлгээний томилгоот багийг тогтмол илгээн ажиллуулна. Түүний хүрээнд хөтөлбөрийн үе шат бүрийн хэрэгжилтийн ахиц, хэрэгжүүлэлтийн зохицуулалтад гарсан аливаа өөрчлөлт, эсхүл ерөнхий Хөрөнгө оруулалтын хөтөлбөр эсхүл тухайлсан төслүүдийн ерөнхий зорилтыг хангахад шаардлагатай засаж, залруулах аливаа арга хэмжээг хэлэлцэнэ.

4.АХБ нь Хөтөлбөрийн үе шат бүрт дунд хугацааны үнэлгээ хийх бөгөөд эхний үе шат хүчин төгөлдөр болсноос хойш цаандаж гурван жилийн дараа Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нарийвчилсан үнэлгээ хийнэ. Дунд хугацааны үнэлгээний хүрээнд төслийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэлтийн зохицуулалттай холбоотой асуудлууд, байгаль орчин болон нийгмийн хамгааллын шаардлага, барилгын ажлын гол зорилтуудын биелэлт, чанарын баталгаажуулалт (үүнд энэхүү СЕХ болоод холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд заасан нөхцөл, болзлын даган мөрдөлт орно)-ын талаар нарийвчлан үнэлнэ. Уг үнэлгээ нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зорилтуудыг хангах үүднээс авч хэрэгжүүлэх өөрчлөлтүүдийг баталгаажуулна.

**5.Төслийн гүйцэтгэлийн мониторинг.** ЭМЯ нь төслийн гүйцэтгэлд мониторинг хийж, улирлын болон жилийн тайлан, АХБ-ны төслийн гүйцэтгэлийн менежментийн системд шинэчлэх шаардлагатай мэдээллийг бэлтгэж, АХБ болон Засгийн газарт хүргүүлнэ.<sup>1</sup> Мониторингийн систем нь гүйцэтгэлийг дараах байдлаар үнэлнэ, үүнд (i) төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ; (ii) бүтээгдэхүүн ба үр дүнг төслийн шалгуур үзүүлэлтээр хэмжиж тайлагнах; (iii) эрүүл мэндийн статистик мэдээлэл цуглуулж, тайлагнах; болон (iv) Засгийн газрын тавьсан зорилтуудад мониторинг хийх. Үзүүлэлтүүд нь төслийн хэрэгжилт, нөөцийн ашиглалт сайжирсан байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байдал, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж сайжирсан байдал, холбогдох Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хангахад гарсан ахиц дэвшлийн талаар тус тус тайлан бэлтгэхэд үндэс болно. Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь дизайн ба хяналт-шинжилгээний хүрээнд тусгагдсан болно. Зарим үзүүлэлтүүдэд төслийн хүрээнд санхүүжүүлэх судалгаанаас эсхүл бусад байгууллагаас авах замаар хянах бол бусад үзүүлэлтүүдийг захиргааны мэдээлэл дээр үндэслэн хянана. Зарим үр дүн болон бүтээгдэхүүний үзүүлэлт нь хүйсээр задлагдах бол зарим нь зөвхөн төсөл хэрэгжиж байгаа газрыг бусад газартай харьцуулах байдлаар хэмжинэ.

**6.Тусгай шаардлагын биелэлтийн мониторинг.** Зээлийн тусгай нөхцөлүүдийн биелэлтийг улирлын явцын үнэлгээгээр үнэлж, тайлагнах ба үүнийг АХБ-ны ажлын хэсэг баталгаажуулна.

**7.Хамгааллын мониторинг.** Төслөөс байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй байдал үзүүлэх нөлөөллийг хяналт шалгалт болон мониторингийн процедурыг тодорхойлсон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-нд заасны дагуу хянана. Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж (ХХН)-ийн байгаль орчин, нийгмийн хамгааллын мэргэжилтэн (хамгааллын мэргэжилтэн) нь зураг төсөл, барилгын ажлын тодорхойлолт бэлтгэсэн инженерийн компани, архитектурын инженер, Нийслэл мөн/эсхүл аймаг, сумын удирдлагатай хамтран барилга угсралтын талбай бүрийг БОМТ-д тусгасан хяналт шалгалт ба мониторингийн хяналтын хуудсыг ашиглан шалгалт хийнэ. БОМТ бүхэлдээ болон аль нэг талбайд хамааралтай БОМТ-ын ерөнхий хэрэгжилтийг төслийн гүйцэтгэлийн менежментийн системд хянах бөгөөд ХХН нь тус нэгжийн хамгааллын мэргэжилтний дэмжлэгтэйгээр түүнийг тайлагнана. Хамгааллын мэргэжилтэн нь барилга угсралтын ажлын явц болон БОМТ-ын ерөнхий хэрэгжилтийн талаар жилийн явцын тайланд нэгтгэн боловсруулж, АХБ-нд тайлагнана (үүнд гэрээлэгчдийн хүлээсэн үүргийн биелэлт, барилга угсралт болон ашиглалтын явцад тулгарсан асуудал болон авч хэрэгжүүлсэн холбогдох арга хэмжээ гэх зэрэг хамаарна). Барилгын ажил дуусмагц хамгааллын

<sup>1</sup> АХБ-ны төслийн гүйцэтгэлийн мониторингийн системийг дараахаас харна уу: <http://www.adb.org/Documents/Slideshows/PPMS/default.asp?p=evaltool>.



мэргэжилтэн, архитектурын инженер, Нийслэл болон аймгийн байгаль орчны газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-ын байцаагч нар тухайн барилгын хэвийн, аюулгүй байдалд шалгалт хийж, баталгаажуулна. Хамгааллын мэргэжилтэн нь ЭМЯ-ны нэрийн өмнөөс ерөнхий БОМТ-ний хэрэгжилтийн эцсийн тайланг барилгын ажил дууссаны дараа 6 сарын дотор нэгтгэн бэлтгэнэ. Хамгааллын мэргэжилтэн нь нөхөн сэргээх ажлаас үүдэн албадан нүүлгэн шилжүүлэлт болон уугуул иргэдтэй холбоотой нөлөөлөл гараагүй болохыг баталгаажуулж, тэрхүү баталгаажуулалт/нягталсан мэдээллийг төслийн байгаль орчны мониторингийн тайлан эсхүл төслийн явцын тайланд тусгана.

8.Жендэр ба нийгмийн мониторинг. Төслийн гүйцэтгэлийн мониторингт нийгэм ба жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НЖУАТ)-т багтсан болно. Тодорхой зорилт бүхий хүрэх түвшин, үзүүлэлтүүдийг тодорхойлсон байгаа болно. Нийгмийн хөгжил, жендэрийн дотоодын зөвлөх нь гүйцэтгэх болон хэрэгжүүлэх байгууллагуудад үр дүнтэй мониторингийн систем нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлж, НЖУАТ-ний хэрэгжилтийг хангах зорилгоор тухайн байгууллагуудад асуудал хариуцсан холбогдох ажилтантай хамтран ажиллана. НЖУАТ-г хагас жилд нэг удаа болоод АХБ-ны томилгоот ажлын үеэр хянаж, тайлагнах болно.

#### **ХУВААРЬ 4**

### **ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БОЛОН БАТЛУУЛАХ ПРОЦЕДУР**

#### **Шалгуур**

Сангийн хүрээнд хэрэгжих дэд төсөл бүр доор дурдсан сонгон шалгаруулалтын шалгуур болон батлах процессийг хангасан байна. Үүнд:

1.Дэд төсөл нь техникийн хувьд хэрэгжих боломжтой байх бөгөөд түүнийг үндэслэх нарийвчилсан тайланг бэлтгэсэн байна;

2.Дэд төсөл нь эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой бөгөөд санхүүгийн хувьд тогтвортой байна;

3.Дэд төсөл нь байгаль орчин, нийгмийн хувьд тогтвортой бөгөөд бэлтгэсэн хамгааллын хүрээ (Хуваарь 5), 2009 онд батлагдсан Хамгааллын бодлогын баримт бичигт тус тус заасны дагуу байгаль орчин, нийгмийн аливаа нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан байна. Дэд төсөл бүрд АХБ-ны ядуурал, нийгмийн үнэлгээний журмын дагуу ядуурал, нийгмийн дүн шинжилгээ хийсэн байна;

4.Дэд төслийг хэрэгжилтийн ерөнхий хуваарийн дагуу цаг тухайд нь үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх үүднээс хангалттай хамтран санхүүжилт хуваарилсан байх; мөн

5.Дэд төслийн саналд асбест агуулсан материал зайлуулах шаардлагатай засвар эсхүл шинэчлэлийн ажил багтсан бол тухайн үйл ажиллагааг дэд төслөөс хассан байна. Төслийг эсхүл дэд төслийг сонгон шалгаруулах, үнэлэх, холбогдох ангилалд хуваарилах, байгаль орчны үнэлгээ хийх болоод тухайн төсөл эсхүл дэд төслийг хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулахаар баталсны дараа байгаль орчны хамгааллын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд БОУХХ-г удирдлага болгоно. Бүх дэд төслийг БОУХХ-тэй заавал нийцүүлснээр шалгуур хангасанд тооцно.

### **Батлах журам**

Монгол Улсын Засгийн газраас АХБ-нд хандан батлагдсан хөтөлбөрт томоохон өөрчлөлт оруулах хүсэлт тавих тохиолдолд Удирдах хороо тухайн хүсэлтийн үндэслэл, ач холбогдлыг хөтөлбөрийн зорилго, зорилт болоод дээр дурдсан шалгууруудын хүрээнд үнэлнэ. Удирдах хороо тухайн хүсэлтийг хэлэлцэн үзсэний дараа түүнийг баталсан эсхүл түүнээс татгалзсан эсэхийг тусгасан хариулт бүхий албан бичиг өгнө.

### **Асбест.**

Хэрэв аливаа бүрэлдэхүүн хэсэгт асбест агуулсан материал зайлуулах шаардлагатай засвар, шинэчлэлийн ажил орсон бол тухайн үйл ажиллагааг ҮШСС-гийн хөтөлбөрөөс хасна.

## **ХУВААРЬ 5**

### **ЯДУУРАЛ, НИЙГМИЙН АСУУДАЛ БОЛОН ХАМГААЛЛЫН ШААРДЛАГУУД**

1.Монгол Улс нь энэхүү Хуваарьт тусгасан шаардлага, болоод Хөтөлбөр болон эхний үе шатад зориулан бэлтгэж, АХБ-наас хуулбарыг бүрэн эхээр хүргүүлсний дээр энэхүү баримт бичигт дурдах байдлаар бүрэн тусгагдсан гэж үзэх дараах байгаль орчин ба нийгмийн хамгааллын хүрээ болон төлөвлөгөөг энэхүү Хөтөлбөрт хамрагдах төслийг боловсруулах болоод хэрэгжүүлэх явцад дагаж мөрдүүлнэ, үүнд:

- (i) 2018 оны 11-р сарын 2-ны өдрийн байгаль орчны үнэлгээ ба хяналтын хүрээ;
- (ii) 2018 оны 11-р сарын 2-ны өдрийн нүүлгэн шилжүүлэлтийн хүрээ;
- (iii) 2018 оны 11-р сарын 2-ны өдрийн уугуул иргэдийн төлөвлөлтийн хүрээ (үндэсний цөөнхийн хөгжлийн хүрээ);
- (iv) 2018 оны 11-р сарын 2-ны өдрийн байгаль орчны анхны үнэлгээ;



(v) 2018 оны 11-р сарын 2-ны өдрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө;

(vi) 2018 оны 11-р сарын 2-ны өдрийн нийгэм ба жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө.

2.Эдгээр баримт бичгүүд нь АХБ-ны хамгааллын бодлогод заасанчлан хөтөлбөртэй холбоотой мэдээлэл, шаардлагыг агуулсан болно. Үүнд: (i) Үе шатлалт санхүүжилтийн сан (ҮШСС)-ийн хүрээнд санхүүжүүлэх магадлалтай бүрэлдэхүүн хэсэг эсхүл төслийн байгаль орчин, албадан нүүлгэн шилжүүлэлт болон уугуул иргэдэд үзүүлэхүйц ерөнхий нөлөөлөл; (ii) төслийг сонгоход ашиглах шаардлагатай хамгааллын шалгуур; (iii) үнэлгээ ба ангилал, нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөөний боловсруулалт, олон нийттэй зөвшилцөх ба мэдээлэл ил болгох (үүнд 120 өдөр ил тавих дүрэм шаардлагатай бол хамаарна), мониторинг ба тайлагналын хүрээнд дагаж мөрдөх шаардлага, процедур; мөн (iv) хамгааллын баримт бичгүүдийг бэлтгэх, хянах болон батлахтай холбоотой институцийн зохицуулалт (төсөв ба чадавхын шаардлагын хамт), зээлдэгч болон АХБ-ны хүлээх үүрэг хамаарна.

3.Уг улсын хууль тогтоомж болон АХБ-ны шинэчилсэн хамгааллын бодлоготой нийцүүлж, ач холбогдолтой байлгах үүднээс тухайн СЭХ-ийг бэлтгэхийн өмнө байгаль орчны үнэлгээ, албадан нүүлгэн шилжүүлэлт болон уугуул иргэдийн хамгааллын хүрээ бүрийн хамаарал, ач холбогдлыг үнэлж, шинэчилнэ.

4.Зээлдэгч нь ямар ч тохиолдолд СЭХ-ийг тухай бүр шинээр бэлтгэхдээ хэрэгжиж буй төслүүдийг байгаль орчин, нийгмийн хамгааллын төлөвлөгөө болон хүрээний хувьд дагаж мөрдөж буй статусаар үнэлж, үнэлгээний тайланг хүсэлт гаргаж буй үе шатанд хамаарах төсөлд хамааралтай бусад шаардлагатай хамгааллын баримт бичгийн хамт АХБ-нд хүргүүлнэ. Хэрэгжиж буй төслийн үнэлгээний явцад зөрчил илэрсэн ямар ч тохиолдолд засаж залруулах төлөвлөгөө боловсруулж, АХБ-нд ирүүлнэ.

5.Дэд төслийн тодорхойлох эхний шатанд АХБ-ны Хориотой хөрөнгө оруулалтын жагсаалт (ХХОЖ)<sup>1</sup> үйлчилнэ. Хэрэв тухайн хөрөнгө оруулалт нь хориотой үйл ажиллагааг санхүүжүүлэхээр бол гүйцэтгэгч байгууллага нь хөрөнгө оруулахаас татгалзана.

6.Нийгмийн ба жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөөг дараах хүснэгтээр харуулав.

<sup>1</sup> 2009 онд батлагдсан ХБББ-ийн Хавсралт 5, хуудас 76-д заасан болно.

## НИЙГЭМ БА ЖЕНДЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаа <b>Үр дүн</b>	Үзүүлэлт/хүрэх түвшин Үе шат 1	Хариуцах байгууллага	Хугацаа	Төсөв
Ховд, Увс аймаг, Улаанбаатар хотын гэр хороолол, бусад сонгогдсон сундын эрүүл мэндийн анхан ба 2 дугаар шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх	<p>а. Ховд, Увс аймаг болон Улаанбаатар хотын гэр хороолол мөн сонгогдсон аймгуудад жилд 96,000 хүн жендэрийн мэдрэмжтэй, үйлчлүүлэгчид ээлтэй өргөтгөсөн ЭМАШ-ны тусламж үйлчилгээ авсан байна (2019 он суурь түвшин: 0)</p> <p>б. аймаг, дүүргийн эмнэлгийн чанартай үйлчилгээг жилд 160,000 хүн авсан байх ба үүнд орчин үеийн эх барих, эмэгтэйчүүд болон мэс заслын тасгийн үйлчилгээ хамаарна</p>	ЭМЯ, СЯ болон НЭМГ	2019–2026	Төслийн төсөв
<p><b>Бүтээгдэхүүн 1 ба Бүтээгдэхүүн 2:</b> Хот болон хөдөөгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх; аймаг, дүүргийн эмнэлгийн үйлчилгээг сайжруулах</p> <p>1.1. Түгээмэл загварын онцлогийг ӨЭМТ болон СЭМТ барилга байгууламжид нэвтрүүлэх</p> <p>1.2. Жендэрийн мэдрэмжтэй, соёлыг хүндэтгэсэн үйлчилгээ болон биет орчинг бий болгох</p> <p>1.3. Шинэ ӨЭМТ болон СЭМТ-д тохируулагчтай эмэгтэйчүүдийн үзлэгийн ороор хангах</p>	<p>1) Улаанбаатар хотын 10 шинэ ӨЭМТ, 6 шинэ СЭМТ-ийн барилга түгээмэл загвартай болсон байна</p> <p>(ii) 10 шинэ ӨЭМТ, зургаан шинэ СЭМТ жендэрт мэдрэмжтэй дизайнтай болсон байна (зөвлөмж, зөвлөгөө өгөх хэсэг)</p> <p>(iii) Эрүүл мэндийн байгууллага бүрт жендэр, нас болон үндэстэн ястны ялгаатай холбоотой ажлын байран дээр мэдлэг олгох дор хаяж нэг удаагийн сургалт явуулсан байна</p> <p>(iv) Казак хэл дээр ӨЭМТ-ийн үйл ажиллагааны талаар танилцуулга/гарын авлага бэлтгэсэн байна (Ховдод зөвхөн Бүтээгдэхүүн 2)</p> <p>(v) 10 шинэ ӨЭМТ болон зургаан шинэ</p>	ЭМЯ, зөвлөх архитектур, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер	2019–2024	Барилгын төсөв



	<p>(i) СЭМТ-д тохируулагчтай эмэгтэйчүүдийн үзлэгийн ороор хангасан байна</p> <p>(ii) Жөндөрт ээлтэй шинэ загвар дүүргийн эмнэлэг</p>			Төслийн төсөв
	<p>(i) ЖСХ/гэр бүлийн хүчирхийллийг таних, ӨЭМТ болон СЭМТ-д шилжүүлэх удирдамжийг боловсруулах</p> <p>(ii) Эмнэлгийн байгууллагын холбогдох ажилтан болон ерхийн эмч нарын дор хаяж 80% нь ЖСХ, гэр бүлийн хүчирхийллийг таних болон удирдамж/ протокол ашиглах талаар сургалтанд хамрагдсан байна (Суурь үзүүлэлт 0)</p>	ЭМЯ болон зөвлөх	2019-2024	
<p>1.4 ЖСХ болон гэр бүлийн хүчирхийллийг илрүүлж, шийдвэрлэх чадвартай ажилчдын чадавч</p>	<p>(i) ӨЭМТ болон СЭМТ-ийн байрлах газар жилд 2 удаа тогтмол өндөр эрсдэлтэй ХБӨ-ний талаар иргэдэд хүрч ажиллах үйл ажиллагаа явуулах</p> <p>(ii) Оролцогчдын тоо ба % (хүйс, нас болон үндэстэн ястнаар ялгасан байх)</p>	ЭМЯ болон зөвлөх	2020–2024	Бүтээгдэхүүн 1 эсхүл 4-ийн хүрээнд явагдах чадавхыг бэхжүүлэх төсөв
<p>1.5 ХБӨа-нөөс урьдчилан сэргийлэх болон (ii) нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, мэдлэг, харилцаа болоод зөвлөгөө өгөх эмнэлгийн ажилчдын чадавхыг сайжруулах</p>	<p>(i) ӨЭМТ болон СЭМТ-ийн байрлах газар жилд хоёр удаа тогтмол өндөр эрсдэлтэй ХБӨ-ний талаар иргэдэд хүрч ажиллах үйл ажиллагаа явуулах</p> <p>(ii) Оролцогчдын тоо ба % (хүйс, нас болон үндэстэн ястнаар ялгасан байх)</p>	ЭМЯ болон зөвлөх	2020–2024	Бүтээгдэхүүн 1 эсхүл 4-ийн төсөв
<p>1.6 ХБӨ-тэй холбоотой эрсдэлийн талаар зорилгот хэсэгт илүү сайн хүрч ажиллах</p>				

<p>1.7 ӨЭМТ болон СЭМТ-ийн удирдлага ба эмч нарын чадавхыг бэхжүүлэх</p>	<p>(i) Эмнэлгийн удирдах ажилчдын дор хаяж 50% (эдгээрийн 50% нь эмэгтэй) эмнэлгийн удирдлагын талаар ур чадвар сайжирсан гэж мэдээлэх</p> <p>(ii) Эмнэлгийн байгууллагын холбогдох ажилтан болон ерхийн эмч нарын дор хаяж 80% нь ЖСХ, гэр бүлийн хүчирхийллийг таних болон удирдамж/ протокол ашиглах талаар сургалтанд хамрагдсан байна (хүйсээр ялгасан)</p>	<p>ЭМЯ болон зөвлөх</p>	<p>2020-2024</p>	<p>Хөтөлбөрийн төсөв</p>
<p>1.8 Жендэр болон үндэсний цөөнхөд мэдрэмжтэй яаралтай тусламжийн үндэсний системийг нэвтрүүлэх (зөвхөн Гарц 1-т)</p>	<p>(i) Дор хаяж нэг Казак хэл бүрэн эзэмшсэн ажилтныг яаралтай тусламжийн үндэсний системд ажиллуулах</p> <p>(ii) Нийт ажилтан 100% жендэр болон үндэстэн ястанд мэдрэмжтэй, соёлыг хүндэтгэсэн үйлчилгээ үзүүлэх тал дээр сургагдсан байна</p>	<p>ЭМЯ болон зөвлөх</p>	<p>2020-2024</p>	<p>Хөтөлбөрийн төсөв</p>
<p>Бүтээгдэхүүн 3. Эрүүл мэндийн санхүүжилтийн системийг бэхжүүлэх</p>				
<p>3.1 Жендэрийг тусгасан эрүүл мэндийн санхүүжилтийн загварыг нэвтрүүлэх</p>	<p>(i) Жендэрийг уялдан тусгасан эрүүл мэндийн санхүүжилтийн загварыг боловруулсан байх</p> <p>(ii) Эрүүл мэндийн санхүүжилтийн загварт хүйсээр ангилсан дата цуглуулах системийг нэвтрүүлсэн байна.</p> <p>(iii) ЭМДБ, ЭМЯ болон СЯ-ны ажилчид дор хаяж 80% (эдгээрийн 50% нь эмэгтэй) хамгаалал, төлөвлөлт болон худалдан авалтын ур чадвараа сайжруулсан гэж мэдээлэх</p>	<p>ЭМЯ болон зөвлөх</p>	<p>2019-2024</p>	<p>Бүтээгдэхүүн 3-ын хүрээнд явагдах стратегийн худалдан авалтын техникийн туслалцаа</p>

Бүтээгдэхүүн 4: Төрийн эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авах ажиллагаа болон санхүүгийн менежментийн чадавхыг сайжруулах		ЭМЯ болон зөвлөх	2019–2024	Төслийн менежментийн зардал
4.1	Нийгмийн ба жөндөрийн дотоодын мэргэжилтний төслийн хэрэгжүүлэлтийн зөвлөхөөр авч ажиллуулах	(i) Нийгмийн хөгжил болон жөндөрийн дотоодын нэг мэргэжилтэн нэгийг авч ажиллуулах (18 хүн-сар, түр) төсөл хэрэгжүүлэлтийн зөвлөхөөр авч ажиллуулах (ii) ЭМЯ/ХХН нь нийгмийн, жөндөрийн мэргэжилтэн авч ажиллуулах (iii) ХХН-ийн ажилтан, ЭМЯ, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын холбогдох ажилтан болон хөтөлбөрт хамрагдсан байгууллагын эрүүл мэндийн удирдах ажилтнуудад хоёр удаа АХБ-ны нийгэм ба жөндөрт тавих шаардлагууд болон НЖУАТ-ний талаар сургалт явуулсан байна		
4.2	Гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч байгууллагууд нь НЖУАТ-г хэрэгжүүлэх, тайлагнах үүрэг бүхий дор хаяж нэг жөндөрийн хөгжил, жөндөр хариуцсан ажилтныг томилно.	(iv) ЭМЯ болон ТХААГ-ын холбогдох ажилтны 60% (дор хаяж 60% нь эмэгтэй)-ийг худалдан авах ажиллагаа, санхүү болон эрсдэлийн удирдлагын талаар сургагдсан байх (суурь түвшин 2019: ХА)		
4.3	ХХН-ийн ажилтныг төслийн үр дүнтэй хэрэгжилт, нэн ялангуяа НЖУАТ-ний хэрэгжилтийн талаар сургах	(v) Хүйсээр ангилсан хөтөлбөрийн гүйцэтгэлийн менежментийн систем НЖУАТ-ний явцын мониторингийн хүснэгтийг хагас жилд нэг шинэчлэх		
4.4	НЖУАТ-нд үр дүнтэй мониторинг хийж, тайлагнах үүднээр хүйсээр задалсан датаг хөтөлбөрийн гүйцэтгэлийн менежментийн системийг ашиглан цуглуулна			
4.5	НЖУАТ-нд хагас жилд нэг удаа мониторинг хийнэ			

ТХААГ = Төрийн худалдан авах ажиллагааны газар, СЯ = Сангийн яам, ЭМЯ = Эрүүл мэндийн яам, ХА = хамааралгүй, ХБӨ = халдварт бус өвчин, ТХЗ = төслийн хэрэгжүүлэлтийн зөвлөх, ЭМАШТУ = эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, ХХН = хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж, НЖУАТ = нийгэм ба жөндөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, СЭМТ= сумын эрүүл мэндийн төв.

<sup>a</sup> Зүрх судасны өвчин, хорт хавдар, хроник амьсгалын замын өвчин, чихрийн шижин гэх зэрэг.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк

## ХУВААРЬ 6 ҮҮРЭГ

Монгол Улс болон түүний Эрүүл мэндийн яам (цаашид “ЭМЯ” гэх), Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (цаашид “НЗДТГ” гэх) болон Төрийн худалдан авах ажиллагааны газар (цаашид “ТХААГ” гэх) нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

### **А.Хэрэгжүүлэх зохицуулалт**

1. Монгол Улс нь Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөтөлбөр (Хөрөнгө оруулалтын хөтөлбөр)-ийг хэрэгжүүлж, түүний бүтээгдэхүүн, үр дүнг цаг тухайд нь хангахад тууштай байх бөгөөд ЭМЯ болон НЗДТГ-г энэхүү үүргийг биелүүлэх нөхцөлөөр хангана.

2. Хөтөлбөрийн замын зураглал, бодлогын хүрээ, Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, эсхүл Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжүүлэх төлөвлөгөөнд өөрчлөлт орох тохиолдолд Монгол Улс нь АХБ-тай хамтран Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт үзүүлэх түүний нөлөөллийг үнэлж, тус хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах, хамрах хүрээнд аливаа өөрчлөлт оруулах эсхүл үргэлжлүүлэх нь зохих эсэх талаар судлан үнэлнэ.

3. Монгол Улс нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөр болоод тус хөтөлбөрт хамрагдах төслүүдийг Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарын авлага (ХХГА)-д нарийвчлан тусгасан зохицуулалтын дагуу хэрэгжүүлэх бөгөөд ЭМЯ болон НЗДТГ-т тийнхүү хэрэгжүүлэх нөхцөлөөр хангана. ХХГА-д оруулах аливаа нэмэлт өөрчлөлт нь Засгийн газар болон АХБ-наас баталсны дараа хүчин төгөлдөр болно.

4. Монгол Улс, ЭМЯ болон НЗДТГ нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон Хөтөлбөрийн хөтөлбөрт хамрагдах төсөл нэг бүрийг СЕХ-ийг Хуваарь 5 болон Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үе шат бүрт хамаарах зээлийн хэлэлцээрт тусгагдсан холбогдох үүрэг ба баталгаа, Байгаль орчны хамгаалал, Уугуул иргэдийн хамгаалал, Албадан нүүлгэн шилжүүлэлтийн хамгаалал, жендэрийн бодлого, хөдөлмөрийн стандарт болон хориотой хөрөнгө оруулалтын зохицуулалтын дагуу хэрэгжүүлнэ.

5. Монгол Улс нь Төрийн худалдан авах ажиллагааны газар (ТХААГ)-г ХХГА-д заасан томоохон барилгын ажлыг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан нөхцөл, болзлын дагуу ЭМЯ-ыг нэрийн өмнөөс худалдан авах нөхцөлөөр хангана. Монгол Улс нь тухайн ТХААГ-г энэхүү СЕХ, холбогдох зээлийн хэлэлцээр болон Худалдан авах ажиллагаанд заасан бүхий л шаардлагыг хангах нөхцөлөөр хангана.

6. ХХГА-д нарийвчлан заасанчлан Хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжих хугацаанд тус хөтөлбөрийн хэрэгжилтэд стратегийн чиглэл, ерөнхий удирдлагаар хангах Хөтөлбөрийн удирдах хороо (ХУХ)-г байгуулна.

7. Монгол Улс нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжих хугацаанд төслийн удирдлага, санхүүгийн удирдлага, инженеринг, худалдан авах



ажиллагаа, байгаль орчин ба нийгмийн хамгааллын хэрэгжилтийн салбарын чиглэлээр хангалттай мэргэшсэн, зохистой хүний нөөцөөр хангах бөгөөд ЭМЯ болон НЗДТГ-г энэхүү үүргийн биелүүлэх нөхцөлөөр хангана. Монгол Улс, ЭМЯ болон НЗДТГ нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжих хугацаанд тус Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн бүхий л ажилтнуудад ажлын байр, барилга байгууламж, тоног төхөөрөмж, туслах ажилтан, харилцаа холбоо болон менежментийн мэдээллийн системээр хангана.

8. Монгол Улс нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжих хугацааны туршид ХХН-ийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллана.

#### **В.Засгийн газрын дэмжлэг**

9. Монгол Улс нь Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлнэ.

10. Монгол Улс нь Хөтөлбөрийг цаг тухайд хэрэгжүүлж дуусгахын тулд шаардлагатай мөнгөн хөрөнгө, барилга байгууламж, үйлчилгээ болон бусад хүч нөөцөөр хангах, эсхүл ЭМЯ, НЗДТГ үе шат бүрийн хэлэлцээрт тусгагдсан өөрсдийн үүргээ гүйцэтгэх боломжоор хангах үүднээс хөрөнгө хуваарилах гэх зэрэг бүхий л шаардлагатай арга хэмжээг авна.

11. Дээр дурдсанаас гадна Монгол Улс нь ЭМЯ, НЗДТГ аливаа ажил, бараа болон үйлчилгээний гэрээнээс үүдэх хариуцлагаа хүлээхэд хангалттай хэмжээний хөрөнгөтэй байх нөхцөлөөр хангана.

#### **С.Эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт**

12. Монгол Улс нь ЭМЯ-аар дамжуулан 2021 он гэхэд журам эсхүл түүнтэй дүйцэх эрх зүйн баримт бичиг батлах замаар эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний нэг иргэнээр тооцох зардлын хувь хэмжээг дор хаяж инфляци, үйлчилгээний зардалтай уялдуулан тогтмол тохируулга хийх санхүүжилтийн механизмыг нэвтрүүлнэ.

13. Монгол Улс нь 2021 он гэхэд эмнэлгийн урсгал зардлын төсвийн төслийн бэлтгэж, лавлагаа шатлалын эмнэлгүүдэд гарц (үйлчилгээний хэмжээ)-д тулгуурласан санхүүжилтийн хуваарилалт хийж, оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлэх төлбөрийн арга ашиглан багц санхүүжилтийн аргаар санхүүжүүлэх замаар 2016 оны Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлнэ.

#### **D.Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт**

14. Зээлдэгч нь ЭМЯ-нд энэхүү СЕХ-ийн Хуваарь 1-т тусгагдсан Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон түүнд хамааралтай аливаа бодлогын шинэчлэлийг цаг хугацаанд нь авч хэрэгжүүлэх нөхцөлөөр хангана.

#### **Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4,5

Индекс: 200003